

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-13
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	14-44
<hr/>	
<i>1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сард Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/</i>	14-16
<i>2.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	16-44

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
11 дүгээр сарын 08-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Саранчимэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 9 цаг 58 минутад Төрийн ордны “Жанжсин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Анандбазар, Т.Аубакир, Ц.Идэрбат, Д.Өнөрболор, Т.Энхтүвшин;
Чөлөөтэй: Н.Ганибал, Г.Мөнхцэцэг, Г.Тэмүүлэн.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Байнгын хорооны дарга Б.Саранчимэг үг хэлэв.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сард Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Саранчимэг “Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сард Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан үг хэлэв.

Б.Саранчимэг: “Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сард Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Мал эмнэлгийн бодлогын асуудал хариуцсан ахлах шинжээч

Х.Алтангэрэл, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа, мөн газрын Мал, амьтан эрүүл мэндийн газрын дарга Б.Болдбаатар, Хяналт, баталгаажуулалтын газрын дарга Б.Батсүх, Гаалийн ерөнхий газрын Хорио цээрийн хэлтсийн дарга Г.Батмөнх, мөн хэлтсийн гаалийн улсын байцаагч Б.Лувсандорж, Хуулийн хэлтсийн гаалийн улсын байцаагч Г.Шүрэнчулуун нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

1.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Ц.Туваан, Г.Ганболд, Ж.Батжаргал, Ш.Адъяаа нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа, мөн газрын Мал, амьтан эрүүл мэндийн газрын дарга Б.Болдбаатар, Хяналт, баталгаажуулалтын газрын дарга Б.Батсүх нар хариулж, тайлбар хийв.

Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Б.Саранчимэг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 14.9, 14.10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 14.9, 14.10, 14.11 дэх хэсэг болгох:

“14.9.Энэ хуулийн 11.1.1-д заасан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хамгаалалттай аж ахуйд мөрдөх биохамгааллын нийтлэг зааврыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга өвчин тус бүрээр баталж хэрэгжилтэд хяналт тавина.

14.10.Хамгаалалттай аж ахуй нь энэ хуулийн 14.9-д заасан нийтлэг зааварт нийцүүлэн өөрийн үйл ажиллагаанд мөрдөх биохамгааллын зааврыг баталж мөрдүүлнэ.

14.11.Энэ хуулийн 14.2, 14.9, 14.10-т заасан журам, биохамгааллын зааврын хэрэгжилтэд үнэлгээ хийх үйл ажиллагааг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцан хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	2
Бүгд:	11

81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 4.1.18 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 4.1.20 дахь заалтын “эсхүл үе хөлтний шимэгчлэл” гэснийг хасах:

“4.1.18.“хамгаалалттай аж ахуй” гэж олон улсын худалдааны чөлөөт байдлыг дэмжих болон улс, бүс, нутагт тархсан өвчнөөс хамгаалах, тэмцэх зорилгоор тандалт, хяналт, эрсдэлийн удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ, биохамгааллын нийтлэг зааврыг хэрэгжүүлэхээр бусад мал, амьтнаас тусгаарлан маллаж байгаа эрүүл мал, амьтан бүхий байгууламжийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “7.4.2 дахь заалт” гэснийг “7.4.2 дахь заалтын “улсын байцаагчаас” гэсний өмнө” гэж, “9.7 дахь хэсэг” гэснийг “9.7 дахь хэсгийн “улсын байцаагч,” гэсний өмнө” гэж өөрчилж, “, 34 дүгээр зүйлийн 34.2.4, 34.3.3 дахь заалтын “дэвсгэрийн” гэсний дараа “мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, төрийн өмчийн мал эмнэлгийн лабораторийн оношилгоо, хүнсний аюулгүй байдлыг баталгаажуулах,” гэж” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 31.4.2, 31.4.4, 31.4.5 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 31.5.2 дахь заалтын “мал эмнэлгийн” гэснийг “мал эмнэлэг, эрүүл ахуй, ариун цэврийн” гэж, 31.5.4 дэх заалтын “худалдаа, үйлчилгээний” гэснийг “худалдаанд мөрдөх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 31.6.4 дэх заалтын “таслан зогсоох” гэсний дараа “талаар хугацаатай үүрэг даалгавар өгөх, хэрэгжилтэд хяналт тавих” гэж нэмж, 31.6.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“31.6.1.мал, амьтан, тэдгээрийн хашаа, байр, ус, бэлчээр, өвс, тэжээлд болон мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн бэлтгэх, хадгалах, тээвэрлэх, худалдах явцад мал эмнэлэг, эрүүл ахуй, ариун цэврийн үзлэг, шинжилгээ хийлгэсэн эсэхэд хяналт тавих;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 31.6.2, 31.6.3 дахь заалтыг нэгтгэж доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“31.6.2.мал, амьтны халдварт өвчин тараах, хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах эрсдэлтэй мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхийг хориглох, шаардлагатай тохиолдолд устгах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд үг хэлж, уг саналыг найруулгын засвартайгаар авав.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 31.6.6 дахь заалтын “мал, амьтны гэжээлийн нэмэлтийг улсын бүртгэлд бүртгэх,” гэснийг хасаж, 31.6.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“31.6.7.Мал, амьтны эрүүл мэндийн бүртгэл, мэдээллийн сангийн хөтлөлтөд хяналт тавих;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 15.13 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.13.Энэ хуулийн 28.2-т зааснаас бусад албан тушаалтан мал, амьтны гоц халдварт өвчний талаарх баталгаажуулах мэдээллийг тараахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “хамгаалалттай аж ахуйд мөрдөх биохамгааллын нийтлэг” гэснийг “хамгаалалттай аж ахуйг баталгаажуулах, хяналт тавих” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3, 4 дэх заалт буюу 34.2.4, 34.3.3 дахь заалтын “баталгаажуулах” гэсний дараа “, мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал.

Б.Саранчимэг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 31.5.2 дахь заалтын “тэдгээрийн гаралтай” гэсний дараа “түүхий эд,” гэж, 31.6.5 дахь заалтын “эмнэлгийн хэрэгсэл,” гэсний дараа “тэжээлийн нэмэлт,” гэж нэмэх.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 4.1.21 дэх заалтын “төлөвлөгөөтэйгээр” гэснийг “төлөвлөгөөний дагуу” гэж, “шаардагдах арга хэмжээ” гэснийг “шаардлагатай арга хэмжээг” гэж өөрчилж, 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 31.5.4 дэх заалтын “амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус” гэснийг “амьтан, тэдгээрийн гаралтай” гэж, 31.6.4 дэх заалтын “борлуулах” гэснийг “худалдах” гэж, 31.6.5 дахь заалтын “гаралтай” гэсний өмнөх “амьтны” гэснийг “амьтан, тэдгээрийн” гэж, 31.6.6 дахь заалтын “малын” гэснийг “мал, амьтны” гэж өөрчлөх.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 4.1.20 дахь заалтын “бүлгийн” гэснийг, 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 31.6.4 дэх заалтын “хүнсний болон хүнсний бус” гэснийг, 31.6.5 дахь заалтын “тэжээл, тэжээлийн нэмэлт, мал” гэснийг, 31.5.4, 31.6.5, 31.6.12 дахь заалтын “мал эмнэлгийн” гэсний дараах “ажил,” гэснийг тус тус хасах.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтыг 1 дэх заалт, 4 дэх заалтыг 3 дахь заалт, 1 дэх заалтыг 4 дэх заалт, 3 дугаар зүйлийн 2 дахь заалтыг 1 дэх заалт болгон өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

2.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, Г.Ганболд, Б.Бейсен нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал нар хариулж, тайлбар хийв.

Ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Б.Саранчимэг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 5.4 дэх хэсгийн 5.4.2 дахь заалтын “гадаад орны” гэсний өмнө “хуульд өөрөөр заагаагүй бол” гэж, 5.4.3 дахь заалтын “экспортлох” гэсний өмнө “шаардлагатай бол” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ үг хэлэв.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 5
Бүгд: 10
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Саранчимэг: Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Саранчимэг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 5.4 дэх хэсгийн 5.4.2 дахь заалтын “гадаад орны” гэсний өмнө “хуульд өөрөөр заагаагүй бол” гэж, 5.4.3 дахь заалтын “экспортлох” гэсний өмнө “шаардлагатай бол” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явууля.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу 3.1.11 дэх заалтын “мал, амьтан,” гэсний дараа “ургамал,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “26.1 дэх хэсэг,” гэснийг “26.1 дэх хэсгийн “эрүүл мэндийг хамгаалах” гэсний өмнө болон” гэж өөрчилж, “8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалтын “байгууллагад” гэсний дараа “цахимаар” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 27.1 дэх хэсгийн “мэргэжлийн баг” гэснийг “эрх бүхий албан тушаалтан” гэж, 27.2 дахь хэсгийн “мэргэжлийн багийн” гэснийг “эрх бүхий албан тушаалтны” гэж өөрчилж, төслийн 2 дахь заалт буюу 26.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 26.4, 26.5 дахь хэсэг болгох:

“26.4.Эрсдэлийн үнэлгээг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилогдсон эрх бүхий албан тушаалтан гүйцэтгэнэ.

26.5.Энэ хуулийн 26.4-т заасан эрсдэлийн үнэлгээ хийх журмыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7.1.7 дахь заалт нэмж, төслийн 6 дугаар зүйлийн “7.1.7,” гэснийг хасах:

“7.1.7.гадаад орны мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн байгууллагатай хяналт, шалгалтын ажлыг уялдуулан хамтран ажиллах, улсын хилээр нэвтрүүлсэн амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүний талаарх мэдээллийг тогтоосон хугацаанд хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахимаар хүргүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “тус тус, 8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалтын” гэсний өмнө “, 25 дугаар зүйлийн гарчгийг “Импортын, олон улсын мал эмнэлгийн, ургамлын хорио цээрийн гэрчилгээ” гэж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 6
Бүгд: 10
40.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Саранчимэг: Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Саранчимэг: 6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “тус тус, 8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалтын” гэсний өмнө “, 25 дугаар зүйлийн гарчгийг “Импортын, олон улсын мал эмнэлгийн, ургамлын хорио цээрийн гэрчилгээ” гэж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн ““мэдээг тогтоосон хугацаанд” гэснийг “тухай бүр”” гэснийг ““хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий” гэснийг “дээд шатны”” гэж өөрчилж, “, 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалтын” гэснийг болон “27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэг,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7 дугаар зүйл.Энэ хуулийг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.2 дахь хэсэг нэмж, төслийн 4 дүгээр зүйлийн “25.2,” гэснийг хасах:

“25.2.Хорио цээрийн хяналт, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний дүн, энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг харгалзан ургамлын хорио цээрийн гэрчилгээг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, олон улсын мал эмнэлгийн гэрчилгээг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн

захиргааны байгууллага тус тус олгоно.” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал.

Б.Саранчимэг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 1.1 дэх хэсгийн “хангах, худалдааг хөнгөвчлөх” гэснийг “дэмжих” гэж өөрчлөх.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 5.4 дэх хэсэг, 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 27.2 дахь хэсэг болон 4 дүгээр зүйлийн “хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн” гэсний өмнө “хүнс,” гэж нэмэх.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтыг 1 дэх заалт болгон өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

3.Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун хариулж, тайлбар хийв.

Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолоор санал хураалт явуулав.

Б.Саранчимэг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

4.Малын генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Б.Саранчимэг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу “9.13, 9.14 дэх хэсэг” гэснийг “9.14, 9.15 дахь хэсэг” гэж, төслийн 3 дахь заалт буюу 9.2.3 дахь заалтын “3-аас” гэснийг “гурваас” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу “16 дугаар зүйлийн 16.12” гэсний дараа “, 16.13” гэж нэмж, 16.13.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.13.4.малын тэжээл, шимт чанар, хүрэлцээ, бэлчээрийн менежмент болон усан хангамж, аймаг дундын отрын бэлчээрийн ашиглалт, хамгаалалт, холбогдох журмын хэрэгжилт, малын гаралтай түүхий эд бэлтгэл;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтыг 1 дэх заалт, 3 дугаар зүйлийн 3 дахь заалтыг 1 дэх заалт болгон өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл.Энэ хуулийг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

5.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Б.Саранчимэг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 5
Бүгд: 10
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Саранчимэг: Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Саранчимэг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

6.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Б.Саранчимэг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “6.63 дахь хэсэг” гэснийг “6.64 дэх хэсэг” гэж, “6.63.” гэснийг “6.64.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “, 8, 9, 10, 11” гэсний дараа “, 12” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл.Энэ хуулийг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Б.Саранчимэг: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 18 минут үргэлжилж, 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 12 цаг 16 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.САРАНЧИМЭГ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
9 цаг 58 минут.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Сарангэрэл: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж ирц 52,6 хувьтай болсон учраас БОХХАА-н байнгын хорооны 2023 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг гишүүний сонгогдсон тойрог, нэрээр танилцуулна. Батсүхийн Саранчимэг Баянзүрх 22 дугаар тойрог ирсэн байна. Цогт-Очирын Анандбазар Булган аймаг 4 дүгээр тойрог томилолттой байна. Тилеуханы Аубакир Баян-Өлгий 2 дугаар тойрог томилолттой байна. Жадамбын Бат-Эрдэнэ Булган аймаг 4 дүгээр тойрог ирсэн байна. Жигжидийн Батжаргал Төв аймаг 14 дүгээр тойрог ирсэн байна. Буланы Бейсен Баян-Өлгий аймаг 2 дугаар тойрог ирсэн байна. Хаянгаагийн Болорчулуун Дорнод 7 дугаар тойрог ирсэн байна. Гочоогийн Ганболд Өвөрхангай 10 дугаар тойрог ирсэн байна. Наянтайн Ганибал Сүхбаатар аймаг 12 дугаар тойрог ирээгүй байна. Гонгорын Дамдинням Дархан-Уул 19 дүгээр тойрог ирсэн байна. Цагаанхүүгийн Идэрбат Хэнтий 18 дугаар тойрог томилолттой байна. Гомтилдоогийн Мөнхцэцэг Дундговь Говьсүмбэр 6 дугаар тойрог ирээгүй байна. Нанзадын Наранбаатар Өмнөговь 11 дүгээр тойрог ирсэн байна. Дамдинсүрэнгийн Өнөрболор Сэлэнгэ 13 дугаар тойрог томилолттой байна.

Ганзоригийн Тэмүүлэн Архангай 1 дүгээр тойрог ирж байна гэсэн. Цэвэгдоржийн Туваан Төв аймаг 14 дүгээр тойрог ирсэн байна. Одонгийн Цогтгэрэл Увс 15 дугаар тойрог ирсэн байна. Төмөртогоогийн Энхтүвшин Дорноговь 8 дугаар тойрог ирж байна гэсэн.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. Хэлэлцэх асуудал Байнгын хорооны тогтоолын төсөл цаглавар батлах байгаа. 2-т Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд байгаа. Анхны хэлэлцүүлэг. 2-т Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг байгаа. Хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай гишүүд байна уу? Алга байна.

Надад нэг санал байна. Энэ дээр нөгөө гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг болох учиртай. Тэгээд ажлын хэсэг нэг дэх өдөр ирц нь бүрдээгүй гэж хэлсэн, одоо сая бас ажлын хэсэг хуралдана гэсэн, одоо бас хуралдаж чадаагүй байгаа учраас ажлын хэсгийн дараагаар бид нар анхны хэлэлцүүлгийг явуулах зарчимтай. Тийм учраас энэ 2 дугаар, 3 дугаар асуудлыг өнөөдөр бас хэлэлцэхгүй болох нь. Хэлэлцэхгүй байж таарах нь. Тэгээд хэлэлцэх асуудлын талаар өөр саналтай гишүүн байхгүй тул хэлэлцэх асуудлаа баталлаа. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сард

*Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн
байнгын хорооны хэлэлцэх асуудлын
цаглавар батлах тухай/*

Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сард БОХХАА-н байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье. Та бүхэнд гар дээр цаглавар очсон байгаа. Тэгэхээр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу Монгол Улсын Их Хурлын дарга 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдөр Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сард хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай 176 дугаар захирамжийг бол баталсан байгаа. Байнгын хорооны энэ тогтоолын төсөлтэй холбогдуулан саналтай гишүүд байна уу? Нэрсээ өгье, кноп. Туваан гишүүнээр тасаллаа. Туваан гишүүн саналаа хэлье.

Ц.Туваан: 11 сар бол манай улсын хувьд бол ингээд ургац хураалт, намрын ургац хураалт энэ тэр хүссэн ч, хүсээгүй ч тэгээд хүйтрээд шувтарч байгаа ийм цаг үе. Тэгэхээр хүмүүс бол ямар ч байсан тарьсан ногоо цагаа, будаа, ногоон тэжээлээ ингээд хураагаад авчихсан. Тэгэхдээ энэ жилийн хувьд бол мэдээж тэр яг ургац хураалтын үеэр 17 хоног гээд бүүр тариаланчдын дунд гарчихсан байна. 17 хоног тасарсан буюу бороотой цаг агаарын сааталтай ийм үе таарсан. Тэгэхээр энэ үе бол ургац хураалт болон ургацын чанарт бол нэлээн нөлөөлсөн гэдэг ийм мэдээллүүдийг өгөөд байгаа юм. Тэгэхээр энэний ар дээр үр дүн дээр юу гарах вэ гэхээр борлуулалтын асуудал хүндэрдэг. Энэ бол ерөөсөө жилийн жилд байдаг асуудал. Тэгэхээр энэ борлуулалтын асуудал бол хүндэрч байгаа мэдээлэл байгаа. Тэгэхээр юу хэлж байна вэ гэхээр ангилан хадсан тарианууд бол балл буюу мөрөн дээрээ харлаж, нэлээн тийм хөгцөрч харлах байдал бол үүссэн. Тэгээд харласан ногоон тэжээл, өвс бол энэ дээр бас хадлан өвс орж байгаа, өвс бол нэлээн чанар алдагдаж ирдэг. Юу

нөгөө төмс хүнсний ногоон дээр бол бас нэлээн хүндрэлүүд үүсчихсэн байгаа.

Тэгэхээр юу хэлэх гээд байна вэ гэхээр манайх салбарын Байнгын хорооны хувиар энэ ХАА-н салбар ялангуяа энэ Төв аймаг, Сэлэнгэ аймгийнхаа ургац хураалтын дүнг нэг сонсоод, тэгээд борлуулалтыг нь нэг яривал яасан юм бэ, үзвэл яасан юм бэ? Борлуулалт дээр ямар хүндрэл байна вэ, энэ хүндрэлийг нь даван туулахад манай салбарын харьяалах Байнгын хорооны хуваарь нэг шийдвэр гаргаад, үзээд шаардлагатай зүйл байвал ЗГ луу асуудлыг тавиад борлуулалт дээр нь дэмжиж өгвөл яасан юм бэ гэсэн ийм саналыг хэлж байгаа юм. Энийг 11 сарын Байнгын хорооны хуваарьт оруулчихвал яасан юм бэ. Энийг болохгүй бол ажлын хэсэгч юм уу эсхүл нэг хэдүүлээ ярьж байгаа ч юм уу газар дээр нь үзэж танилцвал яасан юм бэ гээд. Авсан мэдээллээр бол улаан буудайн борлуулалт дээр бол нэлээн хүндрэл үүсэж байгаа юм. Тэр нь юу гэхээр тариа бол бас түрүүн дээрээ соёолж ургасан энэ тэр асуудлууд бол гарсан. Тэгэхээр юу гэхээр тарианы чанар нэлээн алдагдсан байгаа. Тэгэхээр ийм тариаг бол мэдээж гурилын үйлдвэрүүд авахгүй. Энэ бол гурил хийхэд боломжгүй нэлээн хүндрэлтэй, фотосеператораар ялгахгүй бол ногоон тариа бол тэр гурилын чанарт нөлөөлдөг учраас энэний асуудал байгаа. Тэгэхээр энэ дээр юу, ард нь юу үүсэх вэ гэхээр нэлээд их тариаг улаан буудайг тэжээлийн үйлдвэрүүд рүү шилжүүлэх юм уу эсхүл экспортод гаргах юм уу ийм байдлаар энэ тариаланчдынхаа орлогыг бодохгүй бол энэ тариаланчид маань ер нь жил, жил ямар нэгэн асуудал тулгарсаар байгаад ингээд санхүү эдийн засгийн хувьд ч гэсэн ер нь зарим нь залхсан, уйдсан, ер нь тариа тарихаасаа шантарсан ийм л улсууд байна. Тэгэхээр энэ дээр манай Байнгын хороо 11 сарын хуваарь дээрээ нэг зохион байгуулах ажил тавьж өгөөч гэсэн ийм хүсэлт байна.

Б.Сарангэрэл: Туваан гишүүнд баярлалаа. Тэгэхээр мэдээллийг дараагийн

Байнгын хороон дээр яг бэлтгэл ажлыг нь хангаад, мэдээллийг нь сонсоод, шаардлагатай гэвэл ажлын хэсэг гараад ажиллах бүрэн боломжтой байгаа. Гишүүд санал хэлж дууслаа. Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сард БОХХАА-н байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг батлахыг дэмжсэе гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 90 хувийн саналаар цаглавар батлагдлаа.

10.07 цаг

Хоёр.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалдаа оръё. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Ажлын хэсгийнхнийг оруулаарай. Хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг та бүхэнд танилцуулъя. Ажлын хэсгийг орж ирж байх хооронд хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулагдаж ажилласан. Энэ ажлын хэсгийг Бат-Эрдэнэ гишүүн ахалсан байгаа. Тэгээд Бат-Эрдэнэ гишүүн танилцуулгыг хийе. Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгье.

Ж.Бат-Эрдэнэ: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2023 оны 6 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2023 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр БОХХАА-н Байнгын хороонд шилжүүлсэн. Шилжүүлсэн БОХХАА Байнгын хорооны 2023 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн 12 дугаар тогтоолоор Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, мал, амьтан, тухай амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ миний бие, ажлын хэсгийн гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир, Б.Бейсен, Ц.Идэрбат, Ц.Туваан нар болон ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнд холбогдох байгууллагын албан тушаалтнууд ажиллаж байна.

Ажлын хэсэг 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдөр, 11 дүгээр сарын 7-ны өдрүүдэд тус тус хуралдаж Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх 12, Амьтан, ургамал, тэдгээрийн

гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх 8, хуулийн төслүүдтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийн талаарх 10 зарчмын зөрүүтэй санал боловсруулан, 8 саналыг, санал найруулгын 8 саналыг боловсруулсныг та бүхэнд танилцуулж байна.

Үүнд, 1.Олон улсын худалдааны чөлөөт байдлыг дэмжих болон улс бүс нутагт тархсан өвчнөөс хамгаалах, тэмцэх зорилгоор хамгаалалттай аж ахуйд мөрдөх био хамгааллын нийтлэг зааврыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга нь өвчин тус бүрээр батлах, хамгаалалттай аж ахуй нь дээрх зааварт нийцүүлэн өөрийн үйл ажиллагаанд мөрдөх био хамгааллын зааврыг баталж, мөрдүүлэхээр. 2.мал, амьтны мал эмнэлгийн хяналтын байцаагчийн эрхийг төрийн захиргааны төв байгууллага олгохоор заасан Төрийн хяналт шалгалтын тухай хуульд, хуультай зөрчилдөж байгаа тул тус тус заалтыг хасахаар. 3.эрсдэлийн үнэлгээ хийх журмыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүн батлахаар, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд заасан тул 31-ийн 4.2 дахь заалтыг хасахаар? 4.Гаалийн байгууллага нь улсын хилээр нэвтрүүлэх амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүний талаарх мэдээллийг тогтоосон хугацаанд ХХАА-н асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахимаар бүргэлдэг байхаар. 5.Эрсдэлийн үнэлгээг ХХАА-н асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилогдсон мэргэжлийн баг бус эрх бүхий албан тушаалтан гүйцэтгэх байхаар. 6.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй санал томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн

бүтэц нэр, томьёолол, томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын талаар дугаар зиллэлийг нийцүүлж өөрчлөх зэрэг болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, Ажлын хэсгээс боловсруулсан зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэж өгөхийг, хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

Б.Сарангэрэл: Бат-Эрдэнэ гишүүнд баярлалаа. Өнөөдрийн хэлэлцэх асуудалтай холбогдуулж ирсэн ажлын хэсгийг та бүхэнд танилцуулъя. Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга. Ц.Болорчулуун үгүй ээ энэ чинь эхлээд юу яасан юм чинь. Э.Цолмонжаргал Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Нарантуяа Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга, Б.Болдбаатар Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал, амьтан эрүүл мэндийн газрын дарга, Батсүх Мал эмнэлгийн ерөнхий газрын Хяналт баталгаажуулалтын газрын дарга, Батмөнх ГЕГ-ын Хорио цээрийн хэлтсийн дарга, Алтангэрэл ХХААХҮЯ-ны мал эмнэлгийн бодлогын асуудал хариуцсан ахлах шинжээч, Шүрэнчулуун ГЕГ-ын Хуулийн хэлтсийн гаалийн улсын байцаагч байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хэлэлцэнэ. Гишүүд та бүхэн энэ тухайн зүйлтэй холбогдуулан асуулт асуух болон зарчмын зөрүүтэй санал гаргаж болно. Эхлээд Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуух асуулттай гишүүд байна уу? Зүйл бүрээр нь бид нар ингээд яриад явна.

Туваан гишүүнээр тасаллаа. Дамдинням гишүүн асуултаа асууя.

Г.Дамдинням: Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэг чухал асуудал байгаад байгаа бид нарт. Ямар асуудал байгаа вэ гэхээр бид нар энэ Монгол малынхаа үнэ цэнийг өсгөх, экспортод гаргах, малчдынхаа хөдөлмөрийг орлогыг сайжруулах, хөдөлмөрийг үнэлүүлэх тухай л асуудал яриад суугаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр манай энэ экспортод мал гаргахад энэ нэг олон улсын энэ мал, амьтны энэ нэг конвенцуудыг харахаар 1 дүгээрт бол тухайн улс нь өөрөө бас ийм халдваргүй улс орон болж зарлагдаж болдог. Нөгөө бол тухайн улс орны тодорхой хэсэг өөрөө бас тийм халдваргүй байж бол болдог. Нөгөө болбол 3-д нь манай хуулиар одоогоор байхгүй байгаад байгаа зохицуулалт орж ирж байна гэж хараад байгаа. Энийг би тодруулж асуух гээд байгаа юм. Өөрөөр хэлбэл тухайн ААН өөрөө олон улсын энэ халдваргүйжүүлэлтийн стандарт нормыг бариад, ингээд экспорт хийх шаардлагаа хангаад явж болдог зохицуулалтыг бид нар энэ хуулиараа хийж өгч байгаа юу?

Тэгэхгүй бол бид нар бол малын эрүүл мэнд, тэгээд Монгол мал Үндсэн хуулиар хамгаалагдсан гээд баахан ярьдаг. Тэгээд л жилийн жилд нэг баахан тахал өвчин энэ улс орон даяар тойрч гараад байдаг. Улс орон даяар ингээд тойроод гарчихаар бид нар Монгол Улсаас мал, махан бүтээгдэхүүн, малын бүтээгдэхүүн экспортлох гэхээр нөгөө нэг ариутгал халдваргүйжүүлэлтийн олон улсын стандартаа давж чаддаггүй ийм асуудал үүсээд байдаг. Энэ нь улсынхаа хэмжээнд ингээд бүгдээрээ хохироод мал, амьтныхаа энэ бүтээгдэхүүнийг үнэ хүргэж чадахгүй нөхцөл байдал руу хүргээд, нөгөө талд нь бас энийг нь хийж чаддаг гадна, дотнын хөрөнгө оруулагчид, олон улсын стандартынх нь түвшинд хийж чадаж байгаа хүмүүст ямар ч боломж олгохгүй хаачихсан ийм нөхцөл байдалтай байгаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид нар энэ хуулийн өөрчлөлтөөр 1 дүгээрт энийг засаж залруулж хийж чадаж байгаа юу гэдгийг асуумаар байна.

Энэ хамгаалалттай ААН гээд энэ 14.10 дээр яригдаад байгаа энэ мөн үү? Миний ойлгоод байгаа тийм ээ? Энэ хамгаалалттай ААН гэдэг нь тэр олон улсын гэрээ конвенц дээрээ туссан шууд экспорт хийдэг, Монгол Улсад одоо ингээд л чухам янз янзын малын өвчин гараад л тарлаа. Тэгэхэд энэ ААН өөрөө аюулгүй хамгаалалттай гэдэг ийм лицензтэй баталгаатай, тэгээд олон улсад хүлээн зөвшөөрөгдөөд яг тэндээс бол зүгээр гардаг. Ийм байдлаар хуулиа өөрчилж зохицуулж байгаа юу гэдэг ийм асуулт.

2 дугаарт нь энэ бодвол дагаад баахан л хуулийн өөрчлөлт орох байх. Нэмэлт зөвшөөрөл нэмэгдэж байгаа юу? Зөвшөөрлийн хууль дээр бид нар Зөвшөөрлийн хуулиа л дагаад явах ёстой. Энэ дээр ямар зөвшөөрлүүд.../минут дуусав/

Б.Саранчимэг: Ажлын хэсгийн ахлагч хариулна, шаардлагатай гэвэл харьяа яамнууд яамны ажлын хэсгийнхэн хариулаарай. Бат-Эрдэнэ гишүүн хариулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Тэгэхээр Дамдинням гишүүний асуугаад байгаа асуудал чинь ерөөсөө бид нар энийг л шийдэх гээд байгаа юм л даа. Урьд өмнө зүүн аймгуудад шүлхий гэдэг өвчин гараад ер нь болбол яах вэ зүгээр Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийг боловсруулах боловсруулж явж байх явцад болбол ер нь гадаадад болбол хамгийн гол нэг номерт байдаг чинь шүлхий өвчин. Тэгэхээр шүлхий өвчин урьд өмнө болбол зүүн аймагт л гардаг байсан бол одоо ингээд бүх сумдуудаар бараг л ч 330 сумаар гараад ингээд бас нэлээн тархчихлаа шүү дээ. Олон шалтгаантай байна. Энэ олон шалтгаантай байгаад байна. Хуульдаа бас нэг өөрчлөлтүүд ч байгаад байна. Тэгээд нэлээн зүйлүүд

малчдаасаа авхуулаад нэлээн олон зүйл анги шалтгааныг бол засаж байж энэ дээр орох гээд байгаа юм. Тэгээд энэнээс нэг гарах нь болбол таны түрүүний хэлээд байсан тэр хамгаалалттай аж ахуй гээд байгаа шүү дээ. Хамгаалалттай аж ахуй гэдэг болбол олон улсын стандарт, өөрөөр хэлбэл экспорт, импортоор авч байгаа экспортлогч орнуудын тавьсан шаардлагын дагуу ийм ААН-үүд байгаад тэнд нь өөрсдийн хамгаалалттай бүс бий болгоод, эрүүл бүс бий болгож байгаад, тэгээд тэндээ гарсан бүтээгдэхүүн нь яг цаад экспортод гаргаж байгаа улсын шаардлагын дагуу гардаг ийм бүсийг л бий болгож, хүлээн зөвшөөрөгдөх асуудлыг би ярих гээд байгаа юм 1 дүгээрт.

2 дугаарт энэ асуудлыг ярихын тулд одоо бид нарын үндсэндээ болбол энэ хяналтыг тавьж байгаа нь болбол яг хил дээр ер нь болбол мал анх ингээд л эхээс төрөөд л ингээд л хурга юу байдаг юм, ишиг ингээд л бойжигдоод ингээд явсаар байгаад эцсийн эцэст үйлдвэрийн аргаар боловсруулагдаад, үйлдвэрийн аргаар нядалгаанд ороод, орох хүртэл мал эмнэлэг хариуцаж байгаа юм. Мал эмнэлэг гэдэг чинь өөрөөр хэлбэл Болорчулуун сайдын ХХААХҮЯ-ны харьяанд л эд нар чинь хяналт байж байгаа байхгүй юу даа. Мал эмнэлгийн хяналт. Гэтэл яг энийг нь цаашаагаа экспортод гаргах болохоор хуучин бид нарын яриад байдаг мэргэжлийн хяналтын байгууллага хянаад явчихдаг. Гэтэл яг нөгөө үржүүлдэг, ямар үржүүлэх явцад ямар хэмжээний эрүүл мэндийн юу гаргасан юм, хяналт тавьж байсан юм, ямар вакцинжуулалт эд нар хийсэн юм, ямар орчинд тэжээсэн юм, ямар өвс ургамал өгсөн юм гээд л ингээд бүх гол асуудал нь болбол мал эмнэлэг дээр явж байгаа мөртөөрөө гарах асуудал дээр нь болохоор хяналтын тэрэнтэй ямар ч оролцоо байхгүй хяналтын байгууллага ороод ирж байгаа байхгүй юу.

Тэгэхээр ерөөсөө нэг дор юу яагаад өөрөөр хэлбэл мал, амьтны эрүүл мэндийн

асуудлыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын байгууллага буюу энэ сайд нь толгойгоороо бүх асуудлуудыг нь хариуцаад л, хамгийн сүүлд нядалгаа хүртэл бүх асуудлыг хариуцаад, тэгээд экспортод гаргадаг асуудлуудыг нь ингээд бүрэн хариуцаад өөрөөр хэлбэл мэргэжлийн байгууллагад энэ хариуцлагыг нь болбол бүрэн даалгуулчхаж байгаа юм. Энэ хууль дээр ийм өөрчлөлт оруулж ирж байгаа юм. Бүтцийн хувьд болбол мэдээж хуучин одоо мэргэжлийн хяналтын байгууллага дээр очиж байсан, гааль дээр байсан асуудлууд чинь болбол шилжинэ. Энд болбол хүчин чадлын асуудал ч гэдэг юм уу бас нэлээн зүйлүүд яригдана.

2 дугаарт болбол таны асуусан тэр урьд өмнө нь хийж байсан, зөвшөөрлүүд өгч байсан зөвшөөрлүүд болбол яг тэр хэмжээгээрээ л хариуцагч байгууллагад нь шилжиж байгаа болохоос шинээр болбол нэг тийм зөвшөөрөл бол нэмэгдээгүй байгаа шүү. Ер нь харин ч багасаж байгаа, багасаж байгаа байх шүү.

Б.Саранчимэг: Болорчулуун сайд нэмж хариулъя.

Х.Болорчулуун: Францад төвтэй ОИЕ буюу мал, амьтны эрүүл мэндийн байгууллага бас эрүүл махыг олон улсад экспорт, импортлоход 2 л ийм шаардлага бүхий бүс газар байдаг. Энэ нэгд болбол мал, мал эмнэлгийн дэглэм бүхий эрүүл бүс. Энэ бол том хэмжээний газар. Манай нэг аймгийн хэмжээний газар ч юм уу тийм хэмжээний том хэмжээний газар болохоор эрүүл бүс гэж томьёолж байгаа юм. Жижигхэн нэг сумын хэмжээний газрын бүүр суман дотор аж ахуй байгуулж, хамгаалагдсан аж ахуй хийхийг болбол хамгаалагдсан аж ахуй гэж ингэж 2 ангилж байгаа юм. Тэгэхээр энэ хуулиар болбол аль алиныг нь орж байгаа. Хамгаалагдсан аж ахуй байхад яг технологийн дагуу хамгаалагдсан аж ахуй, аж ахуйгаа явуулаад хяналтдаа ингээд байж байхад хажууд нь

шүлхийтэй мал ойрхон гарсан ч байсан тэр хамгаалагдсан аж ахуйд болбол ямар ч нөлөө үзүүлэхгүй ийм байдлаар технологийн зохицуулалт хийгдсэн байдаг гэдгийг бас хэлье.

Ингэснээрээ бид нар энийг хуульчлаад, энэ эрүүл бус хамгаалагдсан аж ахуйн дагуу мал махаа бэлтгэснээрээ бид нар махаа цаашидаа олон улсын зах зээл дээр бусдын адил үнэтэй гаргах ийм боломж нээгдэж байгаа юм. Тэгэхгүйгээр бид нар энэ урагшаа чанаж энэ тэр гаргаж байгаа энэ тэр бол арга ядсан л 2 улсын хоорондын нэг хэлэлцээрээр гаргаж байгаа асуудал шүү дээ гэдгийг хэлье.

2 дугаарт одоо энд тэндгүй өвчин гардаг байсан. Энэ болбол таслан зогсоогдох уу гэж асууж байна. Өвчин болбол нэг хэсэг бол бид нар вакцин дээр гар татсан байсан. Вакцин тарилга туулгын энэ хөрөнгө санхүүжилт гар татдаг байсан. Үүний улмаас бас нэг шалтгаан нь болбол өвчин гарах бас нэмэгдэх үндэс болж байсан. Харин хүнсний хангамж аюулгүй байдлын 36 дугаар тогтоолын үр.../минут дуусав/

Б.Саранчимэг: Нэг минут нэмж өгье. 36 дугаар тогтоолын үр дүнд вакцин тарилгын мөнгийг бол хангалттай тавьж өгсөн. Жилд дунджаар 40 орчим тэрбум тавьж байгаа. Тэгээд түүнээс гадна нэг дутагдалтай зүйл бол мал эмнэлгийн төрийн өмнөөс үйлчилж байгаа хувийн мал эмнэлгийн үйлчилгээний хөлс хэтэрхий бага байсан. 400, 250, 450 байсан. Энийг болбол 24 оны төсөв дээр 1350 болгож байгаа. Ингэснээрээ болбол бас малын эмч нар бас идэвхжиж нэг ширхэг малыг ч гэсэн үлдээхгүйгээр, нэг толгой малыг ч үлдээхгүйгээр бас эмнэх үйлчилгээ явуулах ийм боломж бүрдэх юм гэдгийг хэлье.

Б.Саранчимэг: Баярлалаа. Дамдинням гишүүн тодруулъя.

Г.Дамдинням: Ойлголоо. Ямар ч байсан энэ экспортод мал гаргахад

хэрэгтэй мал махан бүтээгдэхүүн гаргах, малын бүтээгдэхүүн гаргахад хэрэгтэй байгаа зайлиггүй нэг хуулийн өөрчлөлт бол орж ирээд хийгдэх гэж байгаа юм байна. Ер нь бол энэ ААН-үүд нь өөрсдөө хүсэлт тавиад байгаа юм. Бид нар өөрсдөө хийе, улсын хэмжээнд бол бид нар чадахгүй, бүсийн хэмжээнд манай улс чадахгүй байна, ААН-үүд өөрсдөө хийе энийг. Тэгээд энэ зохицуулалтыг бол хийх нь зөв. Нэг асуулт байна. Ямар асуулт байгаад байгаа вэ гэхээр энэ орон нутгаас ч гэдэг юм уу ингээд мал мах аваад ингээд хэрэглэхээр юу нь мэдэгдэхгүй идээ бээрдээ баригдчихсан, юу нь хамаагүй юм баахан тарьчихсан Монголын хөдөөгөөр ийм мал мах ер нь их ирдэг болж байна гэж энэ олон түмэн их шүүмжилдэг болж байна. Тэгэхээр энэ малд гарал үүсэл нь тодорхойгүй ийм, ийм юм байдаг уу юу байдаг вэ мэдэхгүй, тэгээд төрөл бүрийн л юм орж ирж таригддаг юм шиг байна. Энийг хатуу хориглох, шийтгэлтэй болгодог ийм зохицуулалт хийж болохгүй юу? Энэ хууль хил гааль дээр нь барьдаг ийм юмнууд руу нь оруулахгүй бол наадах чинь бол малын эрүүл мэнд, тэгээд хүний эрүүл мэнд рүү л орно л доо. Юу идэж байгаа нь мэдэгдэхгүй, юу хийсэн нь мэдэгдэхгүй, гарал үүсэл нь тодорхойгүй ийм л юм руу яваад байгаа байхгүй юу. Энийг хорих тал дээр ер нь хууль дээр ямар зохицуулалт хийгдэх юм бэ?

Б.Саранчимэг: Болорчулуун сайд хариулах уу?

Х.Болорчулуун: Мал, амьтны дэглэм бүхий эрүүл бүс, хамгаалагдсан аж ахуй энэ тэр байгуулагдсанаараа болбол мал өөрөө бүртгэл хяналтад орж байгаа юм. Ялангуяа хамгийн их паразит тээгч үхэр гэхэд 40, 50-аад төрлийн паразитыг тээдэг гэж үздэг. Үхэр дээр болбол бүрэн нөгөө бүртгэл хяналтад орно. Өөрөөр хэлбэл нөгөө ээмэгжүүлнэ гэсэн үг. Энэ бол олон улсын шаардлага. Манайхаас өөр бод малаа, үхрээ ээмэгжүүлээгүй, бүртгэлийн санд оруулаагүй улс дэлхийд байдаггүй юм билээ. Бид бол энийгээ гол юмаа хийхгүй

орхигдуулсан. Энийг ч бас олон түмэн мэдэхгүй, ээмэгтэй ээмэггүй бид яах вэ, малаа зүс танина гэх гэсэн байдлаар ханддаг. Тэгсэн мөртөө мал махны үнэ буурлаа, гадагшаа экспортод гаргаа ч гээд байдаг. Бид нар экспортод гаргахын тулд үнэ цэнтэй гаргахын тулд л энд ажлыг хийж байгаа юм гэдгийг л хэлэх байна. Энэ болбол ингээд энийг бүртгэл хяналтад оруулах асуудал болбол энэ 2 бүсээсээ хамгаалагдсан аж ахуйгаасаа болбол эхлэх юм гэдгийг бас хэлье.

Б.Саранчимэг: Ажлын хэсгийн ахлагч Бат-Эрдэнэ гишүүн хариулья нэмж.

Ж.Бат-Эрдэнэ: Ийм байгаа юм Дамдинням гишүүнээ. Одоо ерөөсөө техникийн зохицуулалт гээд нэг зүйл байгаа. Үүгээр бид нарын энэ нөгөө худалдааны байгууллагаас ч байдаг юм уу, зах дээрээс ч байдаг юм уу мал авдаг, дотор нь ингээд янз янзын юм яваад байна шүү дээ. Одоо энэнээс гарах ганц гарц болбол ерөөсөө хүнсэнд гарч байгаа бүх мал мах зөвхөн хүнсний зөвшөөрөгдсөн хүнсний үйлдвэрээр нь нядалгаанд оруулаад тараагддаг ганцхан л энэ зүйлийг л бид нар хийх ёстой. Хэрвээ энийг хийж чадвал энэ уг нь 25 оны техникийн зохицуулалт нь гарчихсан, 25 оны 1 сарын 1-нээс гээд байгаа байх. Би тэгж ойлгож байгаа шүү хэрэгжинэ гээд. Хэрвээ бид нар энийг хэрэгжүүлэх юм болбол тэр орж ирж байгаа мал чинь тийм малчны тэдэн тийм, тийм мал, тийм, тийм эрүүл мэндийн бичигтэй, тэгж, тэгж вакцин юмаа хийлгэсэн, тэдэн хугацаанд болбол тэр вакциных нь хугацаа дууссан гээд бүх зүйлийг нь бүртгэлийг нь тэр малын эмч өөрөөр хэлбэл тухайн үйлдвэр болгон, нядалгааны үйлдвэр юун дээр болгон тийм ээ нядалгааны махны үйлдвэр болгон дээр малын эмч зогсож байгаад орж ирсэн малыг нь бүгдийг нь бүртгэлжүүлээд эрүүлийн шаардлагыг нь хангасан, эрүүл ахуйн шаардлага хангасан бүх малыг нь хүлээж аваад, нядалгаанд оруулаад хамгийн эцэст нь тамгаа дараад гарах ёстой байхгүй юу даа. Ингэсэн

тохиолдолд 1 дүгээрт болбол энэ чинь хүссэн, хүсээгүй ямар мал орж ирээд, эрүүл мал орж ирж байна гэдэг чинь бүртгэлд 1 дүгээрт орчихно.

2 дугаарт гарч байгаа мал чинь ер нь хүнсэнд очиж байгаа хүнсний үйлдвэр ч байна уу, юу нь ч байна зах дээр ч очиж байна уу зөвхөн энэ үйлдвэрээр дамжихад тэнд хяналт тавиад эцсийн хяналтыг Мал эмнэлгийн газар хяналтаа тавиад гаргачихад, ингээд бидний хэрэглэж байгаа ахуйн хэмжээнд хэрэглэж байгаа мал чинь болбол эрүүл мах ороод ирж байгаа байхгүй юу. Яах вэ тэр өнөөдрийн бид нарын хөдөө хээрээр бойнд орж ирж байгаа энэ болбол яах вэ хүнсний өөрсдийн хэрэглээнд бол хэрэглэх юм байгаа биз. Гэхдээ яг хүнсний үйлдвэр, зах барааны энэ хүнсний үйлдвэрүүд, дэлгүүрүүдээр зарагдаж байгаа мах маань одоо ийм нөхцөлд бий болгож байж л эрүүл болох гээд байгаа юм шүү ер нь бол. Энийгээ л бид нар энэ техникийн зохицуулалтаа л маш яаралтай л хийх ёстой. Энэ маань болбол.../минут дуусав/

Б.Саранчимэг: Баярлалаа. Туваан гишүүн асуултаа асууя.

Ц.Туваан: Энэ нэлээн урт нэртэй хууль орж ирж байна. Тэгээд ер нь бол яах вэ энэ дотор орж байгаа зүйл заалтууд бол зөв. Тэгээд манайхан нэг ийм хууль оруулж ирээд тэгээд нэг эрх мэдлийг нэг газар төвлөрүүлэх ийм хандлага харагддаг шүү. Тэгэхээр энэ асуудлыг битгий гаргаарай. Юу хэлж байна гэхээр энэ дахиад л энэ хууль дотор чинь 2, 3 газар энэ хамгаалалттай аж ахуйд мөрдөх био хамгааллын нийтлэг заавар л гэнэ, ахиад энэ хамгаалалттай аж ахуйд мөрдөх био хамгааллын хамгаалалт аж ахуйг баталгаажуулах хяналт тавих л гэнэ иймэрхүү ингээд нэг тийм гарын үсэгтэй, зөвшөөрөлтэй холбоотой юмнууд л ороод ирдэг юм. Тэгээд л нөгөө төрийн хүнд суртал янз бүрийн юмнууд гардаг юм шүү. Тэгэхээр энийг албан ёсоор анхааруулж хэлж байгаа юм.

2 дугаарт нь энэ хамгаалалттай аж ахуй чинь тэр Замын-Үүдийн тэр амьд мал гаргаад байгаа юу чинь орж байгаа юу тэр мөн үү? Хэрвээ мөн бол энэ дээр тэр нэг тэр заавар баталж мөрдүүлнэ энэ тэр гээд энэ хяналт юмнуудаа бас тавих гэж байгаа нь энэ гээд бас нэг жосоохон борлуулалт явж байгаа энэ юмыг битгий гацаачхаарай. Яагаад вэ гэхээр өнөөдөр бол бид нар бас нэлээн газруудад өвөлжилт хүндэрчихлээ. Төв аймгийн хувьд бол бас нэлээн хэдэн суманд цас их орлоо, ингээд өвөлжилт хүндэрчихлээ. Тэгэхээр яадаг вэ гэхээр мэдээж онд ороход хэцүү энэ мал дараагийн ногоотой залгатал хүндрэлтэй учраас энийг бас борлуулах шаардлагатай байгаа юм. Тэгэхээр энэ борлуулж байгаа, авч байгаа газрууд дээрээ битгий янз бүрийн хорио хориг тээг тавиад, зөвшөөрөл янз бүрийн юман дээр нь бас яагаарай. Тэгэхээр энэ талаар тийм юм байгаа юу байхгүй юу гэж.

2 дугаарт тэр хамгаалалттай аж ахуй тэр мөн юм бол энэ тухайн олон улсад юм уу эсхүл тухайн мал махыг мал махыг импортлож байгаа орны байгууллагаас түүн дээр чинь хяналт тавьдаг юм хум энэ тэр нь чухам ямар байдаг юм гэсэн нэг ийм асуултыг асууя. Тэр 9 дээр байна. Энэ зааснаас бусад албан тушаалтан мал, амьтны гоц халдварт өвчний талаарх баталгаажсаагүй мэдээлэл тараахыг хориглоно гээд. Бид нар бол энэнээс болж бол маш их баларч байсан улсууд ер нь бол. Тэгээд л тэнд шүлхий гарсан энэ гээд л улсаараа блок хэдэн жил ч болов. Тэгэхээр энэ дээр ямар хариуцлага тооцох заалт нь юу байгаа юм бэ? Энийг нэг хэлээдхээч. Тэгээд энэ нөгөө нэг юу байгаа шүү дээ, ямар хариуцлага тооцож байгаа вэ?

Энэ нөгөө нэг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага чинь энэ Мал эмнэлгийн ерөнхий газар юм байгаа биз дээ. Тийм энэ дээр бас түрүүн тэр энэ ХААЯ ч юм шиг харагдаад байсан. Энэ асуултууд дээр.

Б.Саранчимэг: Зүйл зүйлээр нь бас асуугаад явна. Бат-Эрдэнэ гишүүн, ажлын хэсгээс хариулах уу? Болорчулуун сайд хариулъя.

Х.Болорчулуун: Энэ хамгаалагдсан аж ахуй бас тусгаарлагдсан аж ахуй гэж дотроо бас 2 янз байгаа юм. Энэ бол олон улсын шаардлагыг хангасан ийм хамгаалагдсан аж ахуй, бас 2 улсын хоорондын гэрээ хэлцлээр тусгаарлалт хийгдсэн тусгаарлагдсан хамгаалагдсан аж ахуй гэж. Энэ Замын-Үүд дээрх аж ахуй болбол 2 улсын хоорондын гэрээ хэлцлээр хийгдсэн ийм тусгаарлагдсан хамгаалагдсан аж ахуй гэж ойлгож, ойлгох хэрэгтэй гээд хэлье.

2 дугаарт энэ хамгаалагдсан аж ахуйн тухай Монгол Улсын стандарт батлагдана. Энэ дээр болбол манай хувийн хэвшлийнхэн маань идэвхтэй ажиллаж байгаа. MCS, Апу компаниас авхуулаад эд нар болбол хамгаалагдсан аж ахуйг хийгээд эхэлчихсэн шүү дээ. Эд нар маань болбол идэвхтэй манай яамтай харьцаад, энэ стандартыг батлуулахын төлөө ажиллаж байгаа гэдгийг бас хэлэх байна. Тэгэхээр ямар нэг хүнд суртал гаргаад байх юм бол байхгүй.

Б.Саранчимэг: Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж дууслаа. Яг ажлын хэсгээс саналын томъёолол энэ 1 дүгээр зүйлтэй холбогдуулж 2 санал ирүүлсэн байгаа. Санал хураалт явуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 14.9, 14.10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 14.9, 14.10, 14.11 дэх хэсэг болгох:

“14.9.Энэ хуулийн 11.1.1-д заасан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хамгаалалттай аж ахуйд мөрдөх биохамгааллын нийтлэг зааврыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны

байгууллагын дарга өвчин тус бүрээр баталж хэрэгжилтэд хяналт тавина.

14.10.Хамгаалалттай аж ахуй нь энэ хуулийн 14.9-д заасан нийтлэг зааварт нийцүүлэн өөрийн үйл ажиллагаанд мөрдөх биохамгааллын зааврыг баталж мөрдүүлнэ.

14.11.Энэ хуулийн 14.2, 14.9, 14.10-т заасан журам, биохамгааллын зааврын хэрэгжилтэд үнэлгээ хийх үйл ажиллагааг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцан хэрэгжүүлнэ.” гэсэн ийм санал байна. Санал хураалт. 81,8 хувиар санал батлагдлаа.

2 дахь санал хураалт. Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 4.1.18 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 4.1.20 дахь заалтын “эсхүл үе хөлтний шимэгчлэл” гэснийг хасах:

“4.1.18. “хамгаалалттай аж ахуй” гэж олон улсын хуралдааны, худалдааны чөлөөт байдлыг дэмжих болон улс, бүс, нутагт тархсан өвчнөөс хамгаалах, тэмцэх зорилгоор тандалт, хяналт, эрсдэлийн удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ, биохамгааллын нийтлэг зааврыг хэрэгжүүлэхээр бусад мал, амьтнаас тусгаарлан маллаж байгаа эрүүл мал, амьтан бүхий байгууламжийг;” Санал хураалт. 2 дугаар зүйл, санал хураалтыг цуцалъя. Энэ 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуух асуулттай гишүүд нэрсээ өгье. Ганболд гишүүн асуултаа асууя.

Г.Ганболд: Энэ хуулийн төслийг бас анх орж ирж байхад нь би яг байхгүй байж таарсан. Тэгээд зүгээр яг энэ зарим заалтуудыг нь хараад байж байхад нэг их онц шаардлагатай хууль яг мөн үү? Энийг яг ЗГ оруулж ирсэн юм уу, өөр гишүүд өргөн барьсан хууль юм уу? Бид нар энд ямар ч хууль батлаад энийгээ хэрэгжүүлээ гээд тухайн Хятадын ч юм уу тэдний шаардлагыг л хангаж байж л

гаргана шүү дээ. Бид нар энд баахан хамгаалах бүс, тусгаарлах бүс байгуулаад энд баахан өвчнүүдээ энэ мал эмнэлгийн байгууллагын дарга нь өвчин тус бүрээр нь батлаад, тэгээд л Хятадууд ямар шаардлага тавина тэрийг нь хангаж л гаргана шүү дээ. Тэгэхээр зэрэг энэ хууль байхын хэрэг яг юу байгаа юм бэ? Ер нь тэгдэг биз дээ Хятадууд л ийм ийм шаардлага тавиад, авах гэж байгаа хүмүүсийн өмнөөс бид нар энд санаа зовоод л, тэгээд л урдуур нь давхиж орж баахан баталгаажуулалт хийх гээд л, урдуур нь ороод л хорио цээрийн юм яриад л ингээд явах ямар хэрэг байгаа юм бэ ерөөсөө?

Би бол яг тэрний оронд харин хилээр орж ирж байгаа энэ малын гаралтай юм уу, энэ амьтны гаралтай энэ орж ирж байгаа энэ тахиа дээрээ л харин бид нар хяналт тавих, тэрэн дээр л жинхэнэ чичрэх ёстой байхгүй юу. Юу орж ирж байна вэ, Монголчууд юу идүүлэх гэж юм орж ирээд байна гэдэг дээр л бид нар хяналтаа тавьж, лабораторио ажиллуулж ингэж явах ёстой байхгүй юу. Бид нар энд энэ хуулийг батлаад, хэчнээн хамгаалалттай ААН байгуулаад, тэгээд бас дахиад нэг юу гэнэ вэ тусгаарлах тэнд байгаа хашааг бариад ингэлээ гээд тэдний шаардлагаар явна л гэж би түрүүний хэлснээр яг л тийм байхгүй юу. Тэгэхээр болбол энэ яг юу зохицуулах гээд байгаа хууль юм бэ?

Тэрний оронд сая Өвөрхангай аймаг жишээлбэл байна шүү дээ нэг Иран руу 200 мянган бог гаргах гээд ингээд нядалж байгаа. Тэндээ мянган тонны зоорьтой ингээд зоориндоо махаа хийчихсэн. Энд ирээд гаалийн бүрдүүлэлт хийгээд гаргах гэсэн чинь шинжилгээ хийсэн байх ёстой махны дээж авна гээд. За очоод тэндээс нь авчих гэнгүүт тийм юм байхгүй, бүгдийг нь ачиж авчраад энд хөргүүртэй зооринд хийсний чинь дараа шинжилгээ авна гэж байгаа байхгүй юу. Тэгээд л нөгөө ААН-үүддээ давхар ингээд дарамт үүсгээд л, тэнд байгаа баахан тонн махыг чинь нааш нь тээвэрлэж

авчраад энд нэг агуулах хайна, тэнд хийж бөөн мөнгө төлнө, тэгж байж гаргаж байгаа байхгүй юу. Тэгээд энийг л бид нар харин болиулах юмнууд л энд оруулж өгөх ёстой хэрэв баталбал. Тэр ААН-д бид нар тээг дарамт болохгүй, тэнд зоориноос нь дээжийг нь авчхаад энд шинжилгээ өгөөд л ингээд явдаг юм руу л орохгүй болбол бид нар бол энэ хууль бол өөрөө болбол нэг тийм айхтар үр дүнтэй хууль биш.

Б.Саранчимэг: Маш чухал асуулт, их тодорхой асуулт асуулаа шүү. Эхлээд ажлын хэсгийн ахлагч Бат-Эрдэнэ гишүүн хариулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Ганболд гишүүнээ энэ бүүр харин эсрэгээр маш чухал хууль юм. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийг хэлэлцүүлээд явж байх явц, боловсруулаад явж байх явцад бид нар тэр гаднын яг экспортод мал, мал мах худалдаж авч байгаа байгууллагуудтай уулзаж байсан туршилага судлаад харж байхад олон улс болбол ерөөсөө жишээ нь Бразилын, Бразил гадагшаагаа экспорт ер нь маш их гаргадаг. Тэр Бразилын эрүүл мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан сайд нь сайдынх нь хэлсэн дэлхий нийтийн гайхамшигт үг байдаг юм гэнэ лээ. Бразил улсаас гарч байгаа маханд, мах мал маханд хийсэн нэг тун вакцины хариуцлагыг би толгойгоороо хариуцна гэж хэлээд, тэр бол дэлхий нийтэд хүрч байсан үг гэж байгаа юм. Тэгээд Бразилын экспорт сайжирсан, мал мах нь гадагшаа гарсан. Тэгэхээр одоо энэ хуулиар болбол тэр мал махыг анхнаас нь мал үржүүлээд ингээд эхлээд бүх вакцинжуулаад эрүүл байх асуудлыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан энэ Болорчулуун гэдэг сайд эцсийн экспортод гаран гартал нь хариуцлага энэ толгойгоороо үүрэх гээд байгаа байхгүй юу. Дундуур нь хэн нэгэн хяналтын байгууллага орж ирэхгүйгээр, хэн нэгэн эрх мэдэлтэн орж ирэхгүйгээр, хэн нэгэн өөр хүн тэр мал эрүүл гэдэг бичиг баримтыг ингээж өмнөөс нь гаргаж өгөхгүйгээр, энэ бүх гаргаж байгаа бичиг

баримтынхаа хариуцлагыг энэ хүнд хариуцуулах гээд байгаа байхгүй юу.

Жишээ нь гадагшаагаа гарч юу хил дээр гаднаас импортоор орж ирж байгаа мал дээр хүртэл бид нар чинь орж ирж байгаа мал дээр юу билээ хяналт хийж байгаа тийм үү, гарч манай энд гарч яаж байгаа. Энэ хуульд урьд нь болбол баг очиж хариуцлага үүрч байсан. Одоо энд болбол баг биш, баг гэдгийг нь авчихсан. Баг гэдэг чинь юу юм бэ тэр дотор 5 хүн болоод л олонхоороо л гар өргөх гээд байна шүү дээ. Тэнд хэн нэг нь лобби орчихвол тэгээд л олонхоороо шийдсэн гээд асуудал ямар ч хариуцлагагүй болчих гээд байгаа байхгүй юу. Гэтэл энэ хуульд болбол тэд нарын баг гэдгийг нь жишээ нь болиулсан юм. Үнэхээр хариуцаж л байгаа болбол Болорчулуун сайд өөрийнхөө яг тэр мэргэжлийн хүнийг нь томилоод ажиллуул. Эцсийн эцэст тэр дүгнэлт шинжилгээ буруу гарсан болбол Болорчулуун сайд ёстой толгойгоороо хариуц, энэ эрүүл бус мал оруулж ирсэн гэдэг ч юм уу. Ингээд ерөөсөө нэг хариуцлага, бүх хариуцлагыг болбол энэ мал эмнэлгийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тодорхой байгууллагууд болоод энэ сайд дээр нь болбол төвлөрүүлэх гээд байгаа юм л даа. Одоо жишээ нь хүний эрүүл мэндийн асуудлуудыг өөр байгууллага хяналтын байгууллага орж ирчхээд дүгнэлт гаргаад байж болохгүй шүү дээ. Жишээ нь ковидтой холбоотой асуудал гэхэд ковидын шинжилгээ өгсөн гэдгийг өөр байгууллага гаргаж болохгүй. Энийг болбол Монгол Улсын эрүүл мэндийн байгууллага тухайн иргэн эрүүл гэдгийг л тодорхойлж өгнө шүү дээ. Тэрэнтэй адилхан малынхаа эрүүл буюу тэрний хяналтын асуудлуудыг нэг байгууллага дээр нь л төвлөрүүлж байгаа л асуудал юм л даа.

Ер нь тэгэхдээ таны асуултаар болбол Хятадад болбол системээрээ ондоо болчоод байгаа юм. Ганцхан Хятадад энэ нөгөө хяналтын байгууллага нь хяначхаад байгаа шүү дээ. Бусад

улсуудад болбол ерөнхийдөө мал эмнэлэг хариуцсан, эмнэлгийн эрүүл мэнд хариуцсан байгууллага нь л энэ асуудал руу харьцаад байгаа байхгүй юу даа. Яг.../минут дуусав/

Б.Саранчимэг: Энэ дээр нэмж хэлэхэд энэ хуулийг ЗГ өргөн бариад, Их Хурал дээр ажлын хэсэг гараад Бат-Эрдэнэ гишүүн ахлаад явж байгаа. Болорчулуун сайд нэмж хариулъя.

Х.Болорчулуун: Бас мах гэдэг бол хүнсний хүний хүнсний гол хэрэгцээтэй хүнс. Тийм учраас олон улсын шаардлага нь маш өндөр байдаг. Манай улс болбол ганц Хятад биш, 10-аад улсад мах экспортод гаргаж байна. Тэгэхдээ бид нар болбол яг ний нуугүй хэлэхэд болбол мал махаа урсгалдаа байлгаж ирсэн. Бүртгэл хяналтад оруулаагүй, цахим бүртгэлд оруулаагүй. Тийм учраас манай малын мах яг өнөөдөр экспортод гарахдаа хямдхан байгаа юм. Дуртай нь ирээд нэг юмыг нь тохироод авна биз дээ. Нөхцөлөө тохироод гэсэн байдлаар үндсэндээ 3-аас 4,5 доллароор. Хэрвээ бид нар мал эмнэлгийн дэглэм бүхий эрүүл бүс байгуулаад, хамгаалагдсан аж ахуй байгуулаад явбал 7-гоос 10 доллароор гадагшаа экспортод гарах ийм боломжтой болно. Үүнийг болбол эрүүл бүсийг болбол бид Монгол Улс эрүүл бүс байгуулаа гээд зарлахгүй. Мал, амьтны эрүүл мэндийн байгууллага тэр Францад төвтэй ОИЕ зарладаг, махны худалдааг хянадаг. Монгол Улсын тэр газраас, тэр бүсээс мал авч болно гэдгийг зарладаг импортлогч орнуудад. Ингээд импортлогч орон тэрийг ОИЕ-гийн хяналт доор зарласан бүсээс авах хэрэгтэй болдог. Тэгж байж нэг ёсныг ёстой шүүрхийгээр нь идэхээс хүртэл айх аюулгүй тийм эрүүл малын махыг хэрэглэх ийм боломж бүрдэг юм.

Эрүүл бүс дотроо эхлээд вакцинтай эрүүл бүс гээд. Манай хойд Буриад хүртэл Оросын хязгаар Буриад хүртэл вакцинтай эрүүл бүс байгуулчихаад байна шүү дээ. Цаашлаад вакцингүй эрүүл

бүс гэж би хэлдэг байдаг. Энэ бол бүр мах нь үнэтэй. Ийм бас стандарт шаардлагатай байдаг юм. Энэ стандартыг болбол ер нь батлуулна. Энэ дээр бол бас хувийн компаниуд манай яамтай бас хамтраад бас ажиллаж байгаа стандартын байгууллагаараа батлуулна гэдгийг бас хэлье.

Б.Саранчимэг: Ганболд гишүүн тодруулъя.

Г.Ганболд: Тэгээд энэ чинь энэ хууль чинь тэгээд эрүүл бүс байгуулах гээд байгаа юм уу? Эрүүлжүүлэх тийм хашаа байгуулах юм яриад байгаа юм уу? Бүс байгуулах гэж байгаа бол бид нар энэ аймаг бүсээр нь зүүн аймгууд, баруун аймгууд гэдэг юмаараа бүхэлд нь энэ эрүүлжүүлэх тухай асуудлаа ярих ёстой байхгүй юу. Та нарын энэ оруулж ирж байгаа хуульд чинь тэр нэг хамгаалалттай аж ахуй гээд нэг хашаанд хийчихсэн, тэр дотор ороод эрүүлжинэ гэж байхгүй. Орж байгаа бүх малаа шинжилгээ хийж оруулах уу, чадах уу? Харин нэг өвчтэй мал орох юм бол тэр хашаанд байгаа бүх мал чинь өвчтэй болно шүү дээ. Тэгэхээр ингээд бид нар нэг ингээд нэг хамгаалагдсан аж ахуй гээд нэг төмөр хашаа барьчихсан, тэрийгээ ингээд эрүүл бүс болгож байгаа гэвэл энэ чинь өөрөө шал буруу юм байна шүү дээ. Бүс барих гэж байгаа бол хэдүүлээ ингээд отор нүүдлээ зохицуулаад энэ аймгуудаар нь эрүүлжүүлэх, вакцингүй эрүүл бүсээ яг хаана байгуулах юм бэ? Баруун аймгуудад байгуулах юм уу, вакцинтай эрүүл бүсээ хаана байгуулах юм. Тэгвэл энэ дээрээ тэр хувилбарынхаа юмнуудыг оруулж ярих ёстой шүү дээ энэ чинь өөр юм яриад суугаад байх юм.

Тэгээд би бол түрүүн энэ хуулиар харин нэг тэр Өвөрхангайн нэг жишээг ярьсан шүү дээ. Нэгэнт энэ батлах гэж байгаа болбол тэрийг нэг энэ дотор хаана нь оруулах вэ? Тэрийг нэг заагаад оруулчихмаар байх юм. Нааш нь авчирч тэр лабораторийн шинжилгээ хийлгэдэг юмыг. Би бол энэ хуульд л тэр л орох

ёстой байх гэж бодоод байх юм. Тэрэнд хаана нь оруулчихвал боломж байна вэ? Тэрэн дээр нэг энэ мал эмнэлгийн энэ ажлын хэсгийнхэн нэг, дэд ажлын хэсгийнхэн нэг хариулаадхаач.

Б.Саранчимэг: Болорчулуун сайд хариулаад, дээрээс нь ажлын хэсгийнхэн бас нэмж нэг хариулмаар байна.

Х.Болорчулуун: Энэ эрүүл бус байгуулах талаар ЗГ-ын тогтоол гарсан. Баруун 3 аймаг, Увс, Баян-Өлгий, Ховд, Хөвсгөл аймаг, ингээд Дорнод аймаг энэ 5 аймаг дээр эрүүл бус байгуулах ЗГ-ын тогтоол гарсан байгаа. Тийм. ЗГ-ын тогтоолтой юм. Урьд нь болбол манайх болбол баруун 7 аймгийн эрүүл бус байгуулна гээд тэгээд тэрэн дээрээ тавих хяналтаа ч хийж чадахгүй ингээд эрүүл бас байгуулж чадахгүй ийм болсон ийм гашиун түүхтэй. Тийм учраас одоо бол ЗГ-ын тогтоолоор тодорхой бас зааж өгсөн байгаа аймгуудыг. Нэмээд хариулах ажлын хэсэг.

Б.Саранчимэг: 6 номер хариулах уу? Албан тушаалаа хэлээд хариулаад яваарай.

А.Нарантуяа: Мал эмнэлгийн ерөнхий газар Нарантуяа. Би Ганболд гишүүний асуултад бас хариулъя. Ерөнхийдөө экспортод гарч байгаа мах махан бүтээгдэхүүн дээр бол Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори бол шинжилдэг. Гэхдээ яг энэ тохиолдолд бол Мал эмнэлгийн ерөнхий газар бид нараас яг ийм шаардлага гарч Төв аймгийн энэ тохио юу Өвөрхангай аймгийн энэ тохиолдлыг бол бид нар мэдээгүй, бас хэд хоногийн өмнө Ганболд гишүүн бас ингээд ярьж байсан. Тэгээд энэ талаар бол бас лавлаж тодруулъя гэж бодож байна. Ер нь бол Мал эмнэлгийн лаборатори аймаг бүсийн хэмжээндээ бол ер нь бол чадварын хувьд лабораторийн оношилгооны чадварын хувьд бол маш сайн байдаг. Яг экспортод гарч байгаа мах махан бүтээгдэхүүн дээр бол Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв

лаборатори, Нийслэлийн мал эмнэлгийн газрын лабораториор шинжилдэг. Яг тухайн бүс орон нутагт шаардлагатай гэж тохиолдолд бол төвөөсөө хүмүүс явуулаад ажиллуулах боломжтой. Тэгээд яг энэ тохиолдлыг бас ийм манайхаас бол ийм шаардлага гараагүй гэдгийг хэлмээр байна.

Төв аймгийн тухайд бол сая манай сайд бас хэллээ. Яг хамгаалагдсан ЗГ-ын тогтоолд Өвөрхангай аймаг ороогүй ч гэсэн яг тэр тухайн тэр ААН Иран руу гарч байгаа махны тухайд бол тусгаарласан хамгаалагдсан бүс нутагт оруулаад явах боломжтой гэж тийм зохицуулалт хийж болох байх.

Б.Саранчимэг: 5 номер нэмж хариулъя.

Б.Батсүх: Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал эмнэлгийн хяналт, баталгаажуулалтын газрын дарга Батсүх байна. Ганболд гишүүний асуусан асуултад хэлэхэд ерөнхийдөө бол энэ экспортыг дэмжих зорилгоор энэ ЗГ-ын бодлого, сайдын бодлого, салбарын яамны бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор энэ хамгаалалттай аж ахуй гэдэг юмыг хууль дээр нэлээн тодорхой болгож оруулж өгч байгаа юм. Ер нь бол ДМАЭМБ-аас олон улсын худалдааны хорио цээр 6 өвчнөөр албан ёсоор эрүүл тайвныг баталгаажуулдаг. Тэгээд улсаар бүсээр аж ахуйн түвшинд буюу хамгаалалттай аж ахуйн түвшинд энэ баталгаажуулалтыг хийж байж экспорт маань явдаг ийм олон улсын тийм зохицуулалт байдаг.

Манайхаас болохоор экспортыг гаргахын тулд аймаг, нийслэл дээр бүх мал эмнэлгийн байгууллагууд дээр бол мал эмнэлгийн лаборатори ажиллаж байгаа. Ялангуяа хүнсний бүтээгдэхүүний экспортыг бол Улсын мал эмнэлэг ариун цэврийн лабораториор баталгаажуулаад, ингэж экспортын олон улсын мал эмнэлгийн гэрчилгээг бол олгодог байгаа. Мах татаж авч ирж Улаанбаатар хотод

агуулахад байлгах ч гэдэг юм уу тийм ямар нэгэн шаардлага бол манай зүгээс бол байхгүй. Мэдээж үйлдвэрүүд өөрийнхөө агуулах зоориноосоо мал эмнэлгийн байцаагчийн хяналт доор тэр дээжээ авч ирээд манай мал эмнэлгийн сүлжээ лабораториор баталгаажуулалтаа хийлгээд ингээд экспортыг бид нар нэг 1-ээс 2 хоногийн дотор тэрийг цахим хэлбэрээр аваад ингээд явуулж байгаа.

Б.Саранчимэг: 1 дүгээр зүйлийн 2 дахь саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. Түрүүн бас уншихсан байгаа. 63,6 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу? Үгүй, 1 дүгээр зүйл чинь дөнгөж 1 дүгээр зүйл батлагдаж байгаа. Бид нар гучаад санал хураалт байгаа. Батжаргал гишүүнээр тасалъя. Батжаргал гишүүн асуултаа асууя.

Ж.Батжаргал: Тийм энэ уул нь их гол хууль. Тэгээд харин явц дундаа жоохон жижгээр мөнгөтэй л юм ярьцаагаад байна. Мал, амьтныхаа эрүүл мэндийг хамгаалж тайван буюу эрүүл бус нийтээрээ бий болох тухай л асуудал бидний гол зорилго. Тэр дотоод нь иднэ үү, гадаад нь иднэ үү тэр нь бидэнд хамаагүй. Бид малаа эрүүлжүүлэх тухай ярьж байна. Тэр лүүгээ чиглэсэн хууль энэ өөрөө. Бид орхигдуулсан зүйлээ оруулж ирлээ гэж ойлгосон. Хамгаалагдсан аж ахуйн тухай асуудал. Энэ тэгэхдээ 2 талаас нь авч үзэх ёстой болчихоод байгаа юм. 1 дүгээрт энэ хагас суурин буюу суурин аж ахуй дээр мөрдөгддөг стандарт байхгүй юу ер нь бол. Дээр нь одоо бид нар энэ мах бэлтгэж байгаа аж ахуйн байгууллагууд дээрээ үүнийг хийлгэх ёстой юм байна, өөрийнх нь эрүүл бүсийг бий болгуулж байгаад түүнд нь 45 хоногийн гэдэг юм уу хугацаанд байлгаад тэр үйлчилгээ, хяналт шинжилгээ бүх юмыг нь хийгээд гаргах тухай асуудал байгаа юм байна гэдэг ийм зүйлээр бид

төсөөлөөд яваад байгаа. Үүнийгээ илүү нарийсгаж авч үзэх ёстой.

Дээр нь тэр эрүүл бүс тэнд энд энэ тэр гэж ярьдгаа больцгоо. Бусад бүс нь яах юм бэ? МАА-н бүтээгдэхүүнээ, махаа борлуулахгүй байх юм уу? Наадах чинь уг нь эрүүл бүс тухай ярих гэж байгаа бол тухайн өвчлөл хэдий хэмжээний цар хүрээ хамарсан бэ, ямар давтамжтай гарсан бэ, бүх юм судалгаа дээр тулгуурлаж яригддаг зүйл. Гэтэл зүгээр нэг хэдэн нөхдүүд ярьж байгаад л энийг, энийг энэ тэр гэж тийм юм байхгүй шүү дээ. Бас энэ нэг ярьж хөөрч байгаа, гаргаж байгаа шийдвэрүүдээ энэ иргэд олон түмэн, энэ аж ахуй эрхлэгч нарын эрх ашиг, энэ төрийн өмнө тавьчхаад байгаа зорилт юмтайгаа уях ёстой гэж.

Би асуух зүйл рүүгээ орё. Энэ хуулийн хэрэгжилтийг хангуулахад энэ орон нутгийн төрийн захиргааны гэдэг юм уу, нутгийн удирдлагын байгууллагуудын чинь чиг үүрэг дээр нэмэгдэж байгаа юм байгаа юм уу? 2 дугаарт энэ орон нутгийн мал эмнэлгийн байгууллагуудын чинь байнгын хяналтын үйл ажиллагаа яаж явах юм бэ? Мал эмнэлгийн газар гэдэг юм уу, төв лаборатори нь бүх газар очиж ажиллана гэж байхгүй. Тийм учраас тэр сумд байж байгаа мал эмнэлгийн тасгууд яаж ажиллах ёстой юм бэ? Тэр нөхдүүдийн ажиллагааг илүү нарийсгаж, чиг үүргийг нь тодорхой болгож, хариуцлагын давхар хяналтын механизмаа хийж өгөхгүйгээр бид өнөөдөр энэ мал, амьтны эрүүл мэндийн тухай асуудал ярихад төвөгтэй болчихоод байгаа байхгүй юу. Энэ малчдын эрүүл мал, амьтныхаа эрүүл мэндийн асуудлыг анхаарах тэр боловсролыг нь дээшлүүлэх асуудал энэ тэр чинь яригдаж байж сая энэ Дамдиннямын яриад байгаа вакцины үлдэгдэлтэй гэдэг юм уу, вакцин.../минут дуусав/

Б.Саранчимэг: Болорчулуун сайд хариулъя.

Х.Болорчулуун: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Батжаргал гишүүн бас тэнд энэ тэр аймгийг эрүүл бүс болгоно гэж зарлах биш. Бусад нь махаа, мал, махаа борлуулахгүй юм уу гэж байна. Тэгэхээр бид нар бол бас нөгөө хөрөнгө санхүү, энэ боломж дээр тулгуурлаж бас эрүүл бүсийг байгуулах ёстой л доо. Улсаараа эрүүл бүс байгуулна гэдэг бас маш нэлээн зардалтай, бүх малаа ялангуяа бод малаа бүрэн бүртгэл хяналтад оруулна, өөрөөр хэлбэл ээмэгжүүлнэ. Ийм зардал болбол бас одоогоор хараахан байхгүй. Тэр битгий хэл манайх 7, баруун 7 аймгийг эрүүл бүс болгоно гээд чадаагүй. Тийм учраас баруун 3 аймаг, Хөвсгөл, Дорнод гэсэн ийм байдлаар ЗГ-ын тогтоол гарсан байгаа. Бусад нь бол дотооддоо борлуулна. Мөн тусгаарлагдсан аж ахуй хэлбэрээр бас гадагшаа экспортод гарах боломжтой гэдгийг бас хэлье.

Б.Саранчимэг: Орон нутгийн байгууллагууд яаж ажиллах юм бэ, хэн хариулах вэ? 3 номер хариулъя.

Ц.Болорчулуун: Батжаргал гишүүний асуултад нэмж хариулъя. Тэгэхээр одоо энэ хууль батлагдсанаар хамгаалагдсан аж ахуйтай холбоотой энэ зөвхөн хамгаалагдсан аж ахуйн тухайн ойлголт байхгүй. Эрүүл бүс, хамгаалагдсан аж ахуй, хоёулаа хамтдаа явж байгаа. Тэгээд хамгаалагдсан аж ахуйн хэрхэн яаж ажиллах журам батлагдана. Энэ журмаар бүгд зохицуулалт нь бол гараад явах юм. Тэгэхээр өнөөдөртөө бол бид нар яг хамгаалагдсан аж ахуйн журам батлагдаагүй учраас өнөөдөр яг энэ аж ахуй хамгаалагдсан аж ахуй гэдгийг баталгаажуулчихсан аж ахуй бол байхгүй байгаа.

Эрүүл бүсээ бол бид нар мэдээж таны хэлдгээр бусад бүсээ орхигдуулж болохгүй. Тэгэхдээ энэ нь бол эхний ээлжид бид нар нөгөө байгалийн олон улсын жишиг нь бол энэ эрүүл бүс байгуулах нь өөрөө байгалийн б... нэлээд

ашигладаг. Тэгээд энэ бол олон улс олон улсын чанартай энэ хил байна, дээрээс нь хилийн боомтууд дээр байгаа энэ боомтуудаа ашиглаж экспорт хийх боломжийг нэлээд түлхүү эхний ээлжид хардаг учраас энийгээ түшиглээд баруун 3 аймгаас эхлээд эрүүл болгоё л гэсэн байдлаар явуулж эхэлж байгаа юм. Тэгээд дараа нь болбол энэ зүүн талдаа бол хамгаалагдсан аж ахуйн загварыг бий болгочихёё. Энэ маягаар ААН-үүд ингээд дангаараа явж болно, хамтраад хамгаалагдсан аж ахуйг бий болгох замаар явах ийм бололцоотой гэж харж байгаа. Энэ мал эмнэлгийн байцаагч нар бүгдээрээ тасагт байгаа байцаагч нар байцаагчийн эрхтэй байгаа. Тэгээд энэ хууль дээр энэ байцаагчийн энд оролцох эрх үүргийг нэлээд дэлгэрэнгүй тусгаж өгсөн байгаа.

Б.Саранчимэг: Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Болорчулуун чиний ярьж байгаа юм дотроос тэр эрүүл биш гэдэг үг чинь алга болчихоод байгаа юм за юу энэ хууль дотор чинь. Урьдчилан сэргийлэх зорилгоор хамгаалалттай аж ахуйн тухай л яриад байгаа байхгүй юу. Тэр эрүүл бүс гэдэг үгээ оруул наадхаа холбоос өгүүлбэрээр оруулах гэж байгаа бол. Оруулаагүй байж ингээд худлаа яриад байдгаа боль нэг. 2 дугаарт ер нь та хэд энэ Монголын мал, амьтныг эрүүлжүүлье гэж хуулийн төсөл оруулж ирээд байгаа юм уу эсхүл энэ нэг хэдэн мах экспортод аж ахуйнуудын эрх ашгийг хамгаалж оруулж ирээд байгаа юм уу? Баруун, зүүн 2 дээр мал махны өртөг арай хямд байгаа. Тэрийг нь түшигээд хамгийн түрүү юу хийж байгаа эрүүл бүсийн тухай ярьж байгаа байхгүй юу. Энэ Монголын ард түмэн чинь бүгдээрээ энэ МАА-гаа түшиж амьдарч байна. Тийм учраас хэн нь ч малаа эрүүлжүүлэхийн төлөө явж чаддаг, эрүүлжүүлснийхээ төлөө энэ МАА-нхаа бүтээгдэхүүнийг борлуулж чаддаг, эргэлзээгүй борлуулж чаддаг л байх ёстой за юу. Төрийн бодлого ингэж л явах ёстой. Тэрнээс биш нэг тийм

явцуу юманд хөтлөгдчихөөд, далд санаа нь тайлбар юмаараа илэрч гарч ирээд байдаг юм байж таарахгүй шүү нөхдүүд ээ.

Б.Саранчимэг: Ажлын хэсгийн ахлагч Бат-Эрдэнэ гишүүн хариульа нэмж.

Ж.Бат-Эрдэнэ: Одоо бүүр туйлираад явчихлаа Батжаргал гишүүнээ. Энэ бүх Монголын МАА-г хамгаалалттай бүс болгоод жижгэрүүлээ, д жижгэрүүлээд явна гэсэн ойлголт байхгүй шүү дээ. Энэ чинь Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулиараа бид нар чинь хорио цээрийн бүс бүх хоорондоо мал, амьтан холилдоогүй байх, тэгээд бүх хорио цээрийн бүсийг нь тогтоогоод эд нар, хамгаалалтыг нь тогтоогоод бид нар чинь энэ МАА-н бүх эрүүл байх нөхцөл байдлаа Мал, амьтныхаа эрүүл мэндийн тухай хууль дээр олон улсын стандартаар бид нар боловсруулчихсан. Тэр ОИЕ чинь хүлээн зөвшөөрөгдсөн хуулиа бид нар баталчихсан. Одоо ганцхан хэрэгжилт нь бид нар хэрэгжүүлэхэд чинь илүү тодруулах зүйлүүд л байгаад байгаа юм шүү дээ энэ дотор чинь. Түүнээс бол энэ Монголчууд бүгдээрээ л амьдарч байгаа, бүгдээрээ л малчид маань хэд хэдэн зуун 70 сая малаа бид нар эрүүл болгохын тулд, Монгол хүн эрүүл байхын тулд энэ нэмэлтүүд орж ирж байгаа байхгүй юу даа.

Хамгаалалттай бүс гэдэг чинь болбол жижигхэн ААН гэдгийг л хэлээд байгаа шүү дээ. Ийм ААН-үүд өөр байж болно гэдгийг л хэлээд байгаа байхгүй юу даа. Одоо тэр Булган аймгийн Жереми гээд бид нар чинь бүгдээрээ мэддэг шүү дээ. Монгол тэр тэр тэр даяараа л мэдээд байх шиг байна, Жеремигийн аж ахуй гээд. Энэ болбол зүгээр нэг тийм эрүүл аж ахуй байхгүй юу даа. Энэ шиг аж ахуй зөндөө гараг. Энэ нөхцөлийг нь бид нар энэ дотор нэг жижигхэн хэсэг болгож суулгасан маань өнөөдрийн энэ заалттай л холбоотой орж ирж байгаа болохоос

биш томоороо болбол бид нар эрүүл бүстэй байх ёстой, хооронд нь хорио цээрийн хяналт байх ёстой, мал эмнэлгийн хяналт байх ёстой, шилжих хөдөлгөөнийг хорих ёстой. Ерөнхийдөө болбол хариуцлагаа нэмэгдүүлэх ёстой, орон нутгийн хариуцлагыг нэмэгдүүлэх ёстой. Бид нар Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль дээр өөрчлөлт оруулсан, Байнгын хорооноос гаргасан тогтоолдоо хүртэл тухайн бүс нутагтаа хорио цээрийн дэглэм алдсан, өвчин алдсан, шүлхий алдсан Засаг даргад хүртэл арга хэмжээ авъя гэсэн заалтыг бид нар аргаа бараад хүртэл оруулж байсан шүү дээ энэ чинь. Тэгэхээр энэ болбол ерөөсөө жижигхэн асуудлыг нь бид нар өлгөж авч яриад байна. Түүнээс биш энэ дотор чинь нөгөө том хуульдаа болбол том ерөнхий зохицуулалт чинь бүгдээрээ байж байгаа, бүгд байгаа.

Б.Саранчимэг: Гишүүд асуулт асууж дууслаа. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс 1 саналын томъёолол ирүүлсэн байна. Та бүхэнд танилцуульа. Төслийн 2 дугаар зүйлийн “7.4.2 дахь заалт” гэснийг “7.4.2 дахь заалтын “улсын байцаагчаас” гэсний өмнө” гэж, “9.7 дахь хэсэг” гэснийг “9.7 дахь хэсгийн “улсын байцаагч,” гэсний өмнө” гэж өөрчилж, “, 34 дүгээр зүйлийн 34.2.4, 34.3.3 дахь заалтын “дэвсгэрийн” гэсний дараа “мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, төрийн өмчийн мал эмнэлгийн лабораторийн оношилгоо, хүнсний аюулгүй байдлыг баталгаажуулах,” гэж” гэснийг хасах. Санал хураалт. Санал хураалт яваач, дараач. 54,5-аар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйл рүү оръё. 3 дугаар зүйлтэй холбогдуулж асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс саналын томъёолол бэлтгэсэн байна, 6 санал байна.

Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 31.4.2, 31.4.4, 31.4.5 дахь

заалтыг тус тус хасах. Санал хураалт.
Санал 63,6 хувиар дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 31.5.2 дахь заалтын “мал эмнэлгийн” гэснийг “мал эмнэлэг, эрүүл ахуй, ариун цэврийн” гэж, 31.5.4 дэх заалтын “худалдаа, үйлчилгээний” гэснийг “худалдаанд мөрдөх” гэж өөрчлөх. Санал хураалт. 54,5 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 31.6.4 дэх заалтын “таслан зогсоох” гэсний дараа “талаар хугацаатай үүрэг даалгавар өгөх, хэрэгжилтэд хяналт тавих” гэж нэмж, 31.6.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“31.6.1.мал, амьтан, тэдгээрийн хашаа, байр, ус, бэлчээр, өвс, тэжээлд болон мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн бэлтгэх, хадгалах, тээвэрлэх, худалдах явцад мал эмнэлэг, эрүүл ахуй, ариун цэврийн үзлэг, шинжилгээ хийлгэсэн эсэхэд хяналт тавих;” Санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 31.6.2, 31.6.3 дахь заалтыг нэгтгэж доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“31.6.2.мал, амьтны халдварт өвчин тараах, хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах эрсдэлтэй мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхийг хориглох, шаардлагатай тохиолдолд устгах;” Санал хураалт. Санал хураалтыг цуцалъя. Санал хураалт цуцлагдсан байгаа. Адьшаа гишүүн асуултаа асууя гэсэн учраас. Үгүй ээ, цуцалчихсан, цуцалчихсан, хэлчихсэн юм. Санал хураалт цуцлагдлаа. Саяын саналтай холбогдуулж Адьшаа гишүүн асуултаа асууя. Зүгээр бүртгэлдээ орчих, Адьшаа гишүүний микрофоныг өгье. Та яг энэ зүйлтэй холбогдуулж асууна.

Ш.Адьяа: Энэ 31.6.2-той холбогдуулж энэ нэг асуух асуулт байна. Энэ мал, амьтны халдварт өвчин тараах, хүний амь нас эрүүл мэндэд хохирол учруулах эрсдэлтэй мал, амьтны гаралтай түүхий эдийг зах зээлд нийлүүлэхтэй холбоотой энэ дээр чинь энэ үүрэг даалгавар өгнө гэдэг чинь юу гэсэн үг юм бэ? Одоо энэ чинь аягүй замбараагүй болсон шүү дээ. Өвчин тараасан мал хэн дуртай нь аваад явж байдаг, тэрнийг нь өнөөдөр хяналт тавьдаг байгууллага гэж ерөөсөө байхгүй. Ховд аймгийн том жишээ байна шүү дээ. Сүүлийн 2, 3 жилийн өмнө тэр гоц халдварт өвчинтэй мал энэ тэр чинь тээвэрлэдэг, туудаг, худалдаалдаг энд ямар ч хяналт байдаггүй. Тэгээд энэ хугацаатай үүрэг даалгавар өгнө гэдэг чинь юу гэсэн үг юм бэ? Тэгээд энэ өвчнийг үүрэг даалгавар өгөөд байлгаад байх юм уу? Энэ устгана гэдэг асуудлыг чинь энд зайлигүй оруулах ёстой. Хугацаатай үүрэг даалгавар өгч та нар ийм энэ эрсдэлтэй ийм мал, амьтныг, энэ гоц халдвартай ийм үйлдлийг үүрэг даалгавар өгч засна гэж байхгүй. Энийгээ шууд хасах санал оруулж байна. Яагаад гэвэл энэ үүрэг даалгавар өгөх байтугай энэ малаа устгуулдаг хүн бол байхгүй болсон байна лээ шүү дээ. Миний хувийн өмч, би яахаараа өнөөдөр энэ малаа устгуулдаг юм гээд. Тэрнийг устгая гэж шаардлага тавьдаг ч хүн байхгүй, устгуулдаг малчин ч байхгүй. Одоо тэгээд бүүр амар юм боллоо шүү дээ энэ чинь одоо, хугацаатай үүрэг даалгавар гоц халдвартай өвчинд өгнө гэдэг чинь энэ юу гэсэн үг юм бэ? Энийг энэ заалтаас авч хая. Энэ яагаад ийм үүрэг даалгавар өгнө гэдэг ийм заалт оруулсан юм энийг тайлбар хэлж өгмөөр байна.

Б.Саранчимэг: Болорчулуун сайд хариулъя.

Х.Болорчулуун: Адьшаа гишүүний энэ найруулгын чанартай энэ хэлж байгаа санал зөв байна. Хугацаатай үүрэг даалгавар өгөх гэж хууль дээр байх

шаардлагагүй гэж бодож байна. Зогсоох талаар үйлдвэрлэл эрхлэхийг таслан зогсоох талаар холбогдох этгээдэд хуулийн дагуу шаардлага тавих, юу мөн шаардлагатай тохиолдолд устгах гэж энийг найруулж оруулмаар байна. Тэр хугацаатай үүрэг даалгавар өгөх гэж юугаа хийдэг юм бэ? Хууль дээр тийм үг ороод байх шаардлага байхгүй юу энэ чинь.

Б.Саранчимэг: Бат-Эрдэнэ ажлын хэсгийн дарга Бат-Эрдэнэ гишүүн нэмж хариул даа.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ орж ирсэн төслөөрөө болбол таслан зогсоох гэж байсан юм. Тэгэхээр энэ үйлдвэр болгоныг бүгдийг нь таслан зогсоогоод үйл ажиллагааг нь ингээд хаагаад, хаагаад явчих л ийм юу гарчхаад байгаа байхгүй юу, агуулга харагдаад байсан байхгүй юу. Тэгэхээр энэ дотор бас тодорхой хэмжээний шаардлага тавьдаг, тусгай юу хугацаатай үүрэг даалгавар өгдөг, тэгээд энэ шаардлагатай тохиолдолд устгал гээд энэ мал, амьтны халдварт өвчин тараах, хүний амь насанд эрүүл хохирол учруулах эрсдэлтэй мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх үйлдвэрлэл эрхлэхийг гэж байгаа шүү дээ, үйлдвэрлэл эрхлэхийг. Тэгэхээр үйлдвэрлэлийг нь бүгдийг нь таслан зогсоогоод ингээд хаагаад байж болохгүй гэдэгтэй нь холбогдуулж л орж ирж байгаа юм л даа энийг үүрэг даалгавар өгье гэж. Тэгэхгүй болохоор бүгдийг нь тас, тас хаагаад, хаагаад явчихаар ерөөсөө I алдаа дутагдал гарвал бүгдийг нь хаагаад, хаагаад явчих л болчихоод байсан юм. Тийм болохоор энэ үг, үсгийг нь оруулж байгаа.

Ер нь болбол жишээ нь Эрүүгийн хуульд болбол бас юунууд санкцуудыг ингээд юутайгаар дэс дараатайгаар оруулж ирдэг шүү дээ. Тэгээд яг зохих нөгөө шаардлагуудыг нь хийдэг, тэр утгаараа бол арай жоохон зөөлрүүлж орж ирсэн юм байна. Тэгээд та бүхэн бас

харахгүй юу даа. Түүнээс биш үйлдвэрлэлийг бүх хаагаад, хаагаад явчих л утга харагдаад байсан юм.

Б.Саранчимэг: Ганболд гишүүн асуулт асууя.

Г.Ганболд: Яах вэ нөгөө хуулиа бид нар бүгдээрэнг нь харахгүй байгаа учраас бас зарим нэг юман дээр жоохон ойлголт багатай байгаад байна л даа. Тэгэхдээ энэ 31.6.2-оо та нар бүр бүхэлд нь өөрчилж, жаахан найруулахгүй бол энэ чинь таслан зогсоох талаар холбогдох этгээдэд шаардлага тавьж хугацаатай үүрэг даалгавар өгөх, шаардлагатай тохиолдолд устгах гэхээр чинь хүнийг нь л устгах юм болчихоод байна шүү дээ наадах чинь. Тэр этгээдийг нь устгах гээд байна шүү дээ, та нар ойлгож байна уу наадхыгаа? Үгүй ээ наадах чинь тийм болчихоод байгаа байхгүй юу? Холбогдох этгээдийг устгах гээд байна шүү дээ, ойлгож байна уу наадхыгаа. Тэгэхээр энэ энийгээ жаахан анзаар, энэ дээр болбол яах вэ зүгээр энэ устгал гэхээр зэрэг энэ дээр нэг жаахан тийм.

Б.Саранчимэг: Ажлын хэсгийн дарга Бат-Эрдэнэ гишүүн яг энийгээ нэг найруулаад эхлээд нэг уничихмаар байна. Тэгэхгүй бол одоо бид нар яг санал хураалтаа хийгээд явчихаар чинь.../үг тасрав/

Г.Ганболд: Тэгээд энэ дээр яах вэ ер нь энэ нэгэнт энэ устгал, устгалын асуудал орж ирж байгаа дээр, устгалын тухай асуудал орж ирж байгаа дээр байна шүү дээ энэ гоц халдварт өвчин гарсан тохиолдолд одоо нэг зарим тохиолдолд нэг баахан бод мал устгаад нөхөн төлбөр олгоод, тэгээд энийг тэгээд боловсруулаарай.

Б.Саранчимэг: Дэмжчихээд, гүйцээн боловсруулах, найруулгын засвар хийх гэдгээр протоколоор оруулчихъя тэгэх үү? Санал хураалт. Би уншсан, Санал хураалт гишүүдээ анхаараарай. 63,6 хувиар санал дэмжигдлээ.

Протоколд тусгаад гүйцэд боловсруулна шүү.

Дараагийн асуудал руугаа санал руугаа оръё. Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 31.6.6 дахь заалтын “мал, амьтны тэжээлийн нэмэлтийг улсын бүртгэлд бүртгэх,” гэснийг хасаж, 31.6.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“31.6.7.Мал, амьтны эрүүл мэндийн бүртгэл, мэдээллийн сангийн хөтлөлтөд хяналт тавих;” Санал хураалт. 72,7 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу 15.13 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.13.Энэ хуулийн 28.2-т зааснаас бусад албан тушаалтан мал, амьтны гоц халдварт өвчний талаарх баталгаажуулаагүй мэдээллийг тараахыг хориглоно.” Санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйл рүү оръё. 4 дүгээр зүйлтэй холбогдуулж асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс саналын томъёолол 1 санал бэлтгэсэн байна. Төслийн 4 дүгээр зүйлийн “хамгаалалттай аж ахуйд мөрдөх биохамгааллын нийтлэг” гэснийг “хамгаалалттай аж ахуйг баталгаажуулах, хяналт тавих” гэж өөрчлөх. Санал хураалт. 72,7 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Зарчмын зөрүүтэй санал гараагүй байна.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс 1 саналын томъёолол бэлдсэн байна. Төслийн 6

дугаар зүйлийг хасах гэсэн ийм санал орж ирсэн байна. Санал хураалт. Юун дээр яачхав, 63,6 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлийн 3, 4 дэх заалт буюу 34.2.4, 34.3.3 дахь заалтын “баталгаажуулах” гэсний дараах “, мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах” гэснийг тус тус хасах. Санал хураалт. Тийм байна. Ямар сонин юм. 72,7 хувиар санал дэмжигдлээ. Хураачихсан.

Найруулгын 4 санал байна гишүүдээ. 1.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 31.5.2 дахь заалтын “тэдгээрийн гаралтай” гэсний дараа “түүхий эд,” нэмэх гэж, 31.6.5 дахь заалтын “эмнэлгийн хэрэгсэл,” гэсний дараа “тэжээлийн нэмэлт,” гэж нэмэх.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 4.1.21 дэх заалтын “төлөвлөгөөтэйгээр” гэснийг “төлөвлөгөөний дагуу” гэж, “шаардагдах арга хэмжээ” гэснийг “шаардлагатай арга хэмжээг” гэж өөрчлөх, 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 31.5.4 дэх заалтын “амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус” гэснийг “амьтан, тэдгээрийн гаралтай” гэж, 31.6.4 дэх заалтын “борлуулах” гэснийг “худалдах” гэж, 31.6.5 дахь заалтын “гаралтай” гэсний өмнөх “амьтны” гэснийг “амьтан, тэдгээрийн” гэж, 31.6.6 дахь заалтын “малын” гэснийг “мал, амьтны” гэж өөрчлөх.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 4.1.20 дахь заалтын “бүлгийн” гэснийг, 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 31.6.4 дэх заалтын “хүнсний болон хүнсний бус” гэснийг, 31.6.5 дахь заалтын “тэжээл, тэжээлийн нэмэлт, мал” гэснийг, 31.5.4, 31.6.5, 31.6.12 дахь заалтын “мал эмнэлгийн” гэсний дараах “ажил,” гэснийг тус тус хасах.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтыг 1 дэх заалт, 4 дэх заалтыг 3 дахь заалт, 1 дэх заалтыг 4 дэх заалт, 3 дугаар зүйлийн 2 дахь заалтыг 1 дэх заалт болгон

өөрчлөх. Санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдлээ. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Хуулийн төслийн зүйл бүрээр санал хураалт явуулна, хэлэлцүүлнэ. Асуулт асуух гишүүд зүйл бүрээрээ асууна.

1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Бейсен гишүүнээр тасаллаа. Наранбаатар гишүүн асуултаа асууя.

Н.Наранбаатар: Энэ би зөв ойлгож байна уу, буруу ойлгож байна уу? Энэ нэг экспорт хийх болгондоо хүрч ирж яамнаас юу авах юм уу? Зөвшөөрөл гэрчилгээ авч гаргах юм уу? Тэгэхээр чинь яам энэ өөрийнх нь чиг үүрэгт нийцэх юм уу, тийм боловсон хүчин, лаборатори, тийм боломж байгаа юм уу? Бодлогын яам чинь өөрөө ийм механик ажил хийж болж байгаа юм уу? Тэгээд энэ чинь аль хаана байгаа Өмнөговь, Баян-Өлгийн боомтоор экспортлох гэж байгаа ААН-үүд чинь Улаанбаатар хотод ирэх юм уу? Энэ чинь бүүр ААН-үүддээ бүүр их хүндрэлтэй, төвөгтэй юм болгоод хаячхаж байгаа юм биш үү? Ер нь бүх юмыг ер нь дээш нь яам руу төвлөрүүлнэ, хүнд суртал ингээд л Улаанбаатар хотод хүрч ирээд л, тэгээд л экспортлох зөвшөөрлөө ирээд л ингээд л хайгаад л яваад л сайд дээр хүрч очиж уулзах юм уу яах юм бэ? Энэ их сонин л юм болчихоод байх юм. Тийм боломж нөхцөл байгаа юм уу яаманд нь.

Б.Саранчимэг: Болорчулуун сайд хариулах уу? Болорчулуун сайд, дээр нь нэмээд тодорхой асуусан юм чинь та асуулт хэлчих, Болорчулуун сайдын микрофон чинь өгчихсөн. Хэн юм бэ? 3

номерын микрофон, ажлын хэсгээс хариулъя гэж байна. 3 номерын микрофоныг өгье.

Ц.Болорчулуун: Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун. Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр одоо мал эмнэлгийн экспортын гэрчилгээ яг ингээд давхардаад байгаа асуудал одоо байгаа учраас л энэ хууль ингэж явж байгаа. Тэгэхээр бид мал, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний нэг цонхны экспортын системийг нэвтрүүлсэн. Энэ дээр бол хуучин төрийн 7 байгууллагаас нийтдээ 45, 6 бичиг баримтыг бүрдүүлж, 396 цаг буюу 13 хоног ажлын хоног зарцуулж энэ экспортын гэрчилгээг бол авдаг байсан. Тэгээд одоо энэ ХАА-н бирж дээр бид энийг төвлөрүүлээд өглөө 8:30-аас өдрийн 12:30 гэхэд экспортынхоо гэрчилгээг авах нөхцөлийг бол үүсгэсэн байгаа. Энийг энэ төрийн 7 байгууллагын бүрдүүлж байгаа материалуудыг бүгдийг нь цахим системд оруулсан. Тэгээд тухайн ААН бол олон улсын худалдааны гэрээ, ААН-ийн гэрчилгээнийхээ хуулбарыг шивээд, тэгээд бусад холбогдох төрийн байгууллагууд энэ гэрээг үндэслээд зөвшөөрлүүдээ ингээд шаардлагатай материалуудаа аваад, зөвшөөрлөө олгоод явах ийм бололцоо нөхцөлийг цахим руугаа оруулаад авах бололцоо нөхцөлийг бол үүсгэсэн байгаа. Энэ талаараа бид нар удахгүй энэ 15-нд, 11 сарын 15-нд Хөдөө аж ахуйн бирж дээр энэ нийтдээ 26 нэр төрлийн ХАА-н гаралтай бараа, бүтээгдэхүүнийг экспортлох боломж бүрдсэн талаараа энэ бас танилцуулга нээлттэй хийнэ. Энэ дээр Байнгын хорооны гишүүдээ бас урьж оролцуулж, танилцуулъя гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа.

Энэ одоо энэ явж байгаа хуулиараа болбол энэ зөвшөөрөл аваад явж байгаа мал эмнэлгийн гэрчилгээг аваад тэгээд экспортын гэрчилгээг нь мал эмнэлгийн гэрчилгээг үндэслээд гаалийн, Гаалийн ерөнхий газар дээрээс энэ хорио цээрийн гэрчилгээ гэж олгогдож байсан. Тэгээд

энэ бол ингээд давхардаад байсан, экспортын гэрчилгээ. Тэгэхээр энийг болбол нэг болгоё л гэсэн ийм хуулийн зохицуулалт явж байгаа. Тэгэхээр одоо, ер нь бол ХХААХҮ-ийн сайдын энэ Засгийн газрын тухай хууль дээр эрхлэх 16 асуудал байгаа юм. Энэ дээр болохоор хамгийн чухал асуудал нь энэ мал, амьтан, ургамлын хорио цээрийн асуудлыг сайд эрхлэх ёстой. Тэгээд мал, таримал ургамлын гаралтай хүнсний зүйл, түүхий эд болон хөнгөн үйлдвэрийн бүтээгдэхүүний экспорт, импортын асуудлыг бас сайд хариуцах ёстой гээд ингээд тусгаад өгчихсөн байж байгаа гэх мэтчилэн. Хамгийн сүүлд салбарын хяналтын асуудлыг сайд хариуцахаар ингээд тусгаж өгсөн байгаа. Тэгэхээр энэ асуудлууд одоо ингээд яг сайд хэрэгжүүлж чадахгүй ингээд энэ зарим энэ зөвшөөрлүүд нь ингээд гааль дээр нэг хэсэг нь явчхаад байгаа учраас энийгээ нэг болгоё гэдэг зорилгоор л энэ хуулийг оруулж ирж байгаа юм. Энэ хуулиудын давхардал хийдлийг арилгая гээд энэ б хуулийг хамтад нь нэг хууль болгож оруулж ирж байгаа л ийм л асуудал байгаа юм. Одоо тэгээд цахимаар нийтдээ нэг 2150.../минут дуусав/

Б.Саранчимэг: Ганболд гишүүн асуултаа асууя.

Г.Ганболд: Ер нь болбол энэ зөвшөөрөл юмыг бид нар аль болохоор хүний оролцоогүй л болгоё гээд л яваад байгаа л даа. Тэгээд энэ 3 дээр энэ уг нь бол энэ байгууллагад гэсний дараа цахимаар гэж оруулчихсан байсан юм байна. Тэгээд энэ цахим гэдгийг нь бас хасаж байгаа юм байна. Яагаад энэ цахим гэдгээ заавал хүн оролцох гээд байгаа нь ямар учиртай юм бэ? Цахимаар гэснийг нь хасаад оруулсан байх юм.

Дараагийнхад нь энэ мэргэжлийн баг гэснийг болиулаад эрх бүхий албан тушаалтан гэж оруулсан байх юм. Энэ бас яагаад энэ мэргэжлийн баг гэж энэ эхнээсээ оруулж ирсэн юмыг яагаад энэ ажлын хэсэг дээр заавал нэг албан

тушаалтан хэн нэгэн хүнээс хамааралтай болгох гэж энийг оруулав? Би бол ийм л санал байна энэ дээр. Хэн тэр шийдвэрийг гаргаж өгөх нь бол надад ерөөсөө хамаа алга. Хугацаа л чухал, 72 цагийн дотор л сайд нь ч бай, хэн нь ч бай тэр тухайн байгууллага ингээд экспортын хүсэлт өгч байна шүү дээ тийм ээ, тэрийг ерөөсөө 72 цагийн дотор л шийдэж өгдөг л тийм хугацаа л тавьж өгөх ёстой. Үгүй ээ үгүй. Харин тийм учраас энэ хуулийн заалт дээр би бүр хугацаа тавьж өгмөөр байна. Тэгэхгүй бол манайхан чинь бол ингээд дарамтлаад дампууруулж байна шүү дээ ер нь болбол энэ компаниудыг. Тэгэхээр зэрэг байна шүү дээ энэ дээр бол хэн өгөх нь хамаагүй хугацаатай л болох ёстой. Тэгээд тэр хугацаанд шийдэж өгөөгүй тохиолдолд хариуцлагатай л байх ёстой тэр албан тушаалтан. Зөвшөөрөл өгдөг албан тушаалтан хугацаатай, тэр хугацаандаа шийдэж өгөөгүй бол хариуцлагатай ийм л заалт оруулж байж л энэ амилна. Тэрнээс хэн нь дарга байх нь ерөөсөө хамаагүй.

Б.Саранчимэг: Бат-Эрдэнэ гишүүн хариулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Тэр мэргэжлийн баг гэснийг албан тушаалтан гэж би өөрчилсөн юм. Манай энэ төрд нэг тийм хариуцлагаас зугтсан нэг тийм механизм хэлбэр бий болчихоод байна шүү дээ. Юм л бол ажлын хэсэг байгуулна, юм л бол баг байгуулна. Тэгээд л тэр ч байгууллагаас хүмүүс оруулъя, энэ ч байгууллагаас хүмүүс оруулъя энэ тэр гээд л өөрсдөө хариуцсан мөртөөрөө тэгээд нэг их л мундаг асуудлыг шийдэх гээд л нэг их олон хүмүүс оруулчихдаг. Нөгөөдүүл нь эцсийн эцэст гараа өргөхөөрөө яг нөгөө бодлого хийдэг хүний хариуцлагаас шал ондоо шийдвэр гаргуулчихдаг. Янз янзын лобби ороод, 5 хүн байвал олонхоороо шийдээд л явчихдаг. Гэтэл тэр чинь хариуцлагын механизмаа саармагжуулаад байгаа байхгүй юу даа. Жишээ нь гаалиас орж ирж байна гэж байна, гаалиас хэрвээ хариуцлагынхаа асуудлуудыг татаж авчраад өөрсөд дээрээ авна гэххээд юугаа

хийж тэгвэл гаалиас буцаад хүн оруулах гээд байгаа юм бэ? Үгүй ээ тэгээд хариуцна л гэсэн болбол Болорчулуун сайд өөрсдийнхөө хүмүүсийг томилоод л, тэр баг томилоод л тэр хүн нь юугаа хариуцлагатай мэргэжилтнээ томилоод л, тэр хүн нь үзээд, шалгаад л, сайдынхаа өмнө хариуцлагаа үүрээд л яв л даа. Энэ нэг баг байдаг юманд бид нар ер нь хаана сайгүй ийм юм болчихоод байна шүү. Юм л бол ажлын хэсэг байгуулдаг, юм л бол баг байгуулдаг. Тийм болохоор энэ дээр болбол яг мэргэжлийн хүн нь хариуцлагаа үүрээд, очоод тэр шалгадаг үздэг юм болбол өөрөө өөрсдөө очоод үзээд хүнээ томилоод үзье гэсэн байдлаар нь оруулсан юм. Бусад дээр нь болбол ажлын хэсэг хариулаарай.

Б.Саранчимэг: 3 номер нэмж хариулъя.

Ц.Болорчулуун: Ганболд гишүүний асуултад нэмж хариулт өгье. Тэр цахимаар гэдгийг хасаж байгаа нь хойно 7.1.7 дээр цахимаар гээд мэдээллийг нь цахимаар ирүүлнэ гэдгийг нь оруулчихсан байгаа. Тийм учраас энэ дээрээ ингээд хасаад өгчихсөн байж байгаа, давхардаж байгаа учраас. Тэгээд ер нь бол хугацаа ингээд бид нар жишээ нь маш богино болсон. Тэгээд хуучин яг ажлын 13 өдөр байсан юм. Бид нар бүүр ажлын зураглалыг нь авч үзсэн юм. Тэгээд одоо яг 4 цагийн дотор энэ зөвшөөрөл авах ийм нөхцөл бололцоо үүссэн. Ажлын зураглалыг нь хийгээд, гаргаад бид нар ингээд. Тухайн байгууллага ингэж бүх байгууллага дээр очих ямар ч шаардлагагүй болчихож байгаа юм. Оффисын ажлын байран дээрээсээ өөрөө мэдээллээ оруулаад л анхан шатынхаа тэгээд л энэ зөвшөөрөл нь ингээд 4 цагийн дотор гарах л ийм зохицуулалтыг яг ийм нөхцөлийг бүрдүүлчихсэн байж байгаа. Энэ дээр бол мэдээж Гаалийн ерөнхий газар, Статистикийн газар, Худалдаа аж үйлдвэрийн танхим, Мал эмнэлгийн ерөнхий газар, Стандартчилал хэмжил зүйн газар, ХХААХҮЯ гээд төрийн ийм 7 байгууллагын оролцоо байсан, бүгдээрээ л

ижилхэн юм шаарддаг л ийм л байсан. Цаг хугацаа нэлээд зарцуулж байсан. Энийг бол ийм хөнгөвчилж чадсан гэж үзэж байгаа юм.

Б.Саранчимэг: Ганболд гишүүн тодруулъя.

Г.Ганболд: Тэр цахим гэдгийг ойлголоо. Давхардсан юм байна гэж ойлголоо. Зүгээр би Бат-Эрдэнэ ажлын хэсгийн ахлагчийн нөгөө мэргэжлийн баг гэдгийг нь би нөгөө яг ямар шийдвэр гаргах гэж байгаагаас бид нар их шалтгаалмаар байгаа юм л даа. Би яг энэ дээр ямар шийдвэр гаргах юм гэдгийг нь мэдэхгүй байна л даа. Тэр агуулгаараа яах вэ үнэхээр бас тийм, тэгээд тэр нь чухал болбол бас мэргэжлийн баг байх нь, жижиг сажиг юманд бол яах вэ тэгээд албан тушаалтан гаргаад явахад бол болохгүй юм байхгүй л дээ. Тэгээд сая 4 цагийн дотор гаргадаг болчихсон л гээд байх юм. Тэр чинь өмнө нь бас нэг бичиг баримтыг нь бүрдүүлчихсэн тохиолдолд л 4 цаг уу? Ерөөсөө огт юм бүрдүүлээгүй очоод л тэнд нь 4 цагийн дотор бүгдийг нь бүрдүүлээд авах боломж байна уу? Тэгээд энэ дээр ер нь нэг зүгээр ер нь нэг хугацаа заагаад өгчихөд ер нь буруугүй дээ. Юу ч бүрдүүлээгүй байхад шууд 4 цаг болох уу? Очоод л ерөөсөө огт юу ч бүрдүүлээгүй, очих ч үгүйгээр үү? Тэгвэл сайн л байна.

Б.Саранчимэг: Бат-Эрдэнэ гишүүн нэмж хариулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ нөгөө мал импортлоход мэргэжлийн баг хилийн цаана гарч, мэргэжлийн байгууллагуудтай ажиллаж, эрсдэлийн үнэлгээ гаргана гээд байгаа юм. Энэ дээр баг гэдгийг нь, тийм хилийн цаана гарч тийм. Тэгэхээр хилийн цаана гарна, тэгээд л нэг олуулаа явна, тэгээд л нэг их тийм нэг л айхтар нэг мэргэжсэн хүмүүс нэг бүүр олуулаа очоод л үзэж хардаг. Тэр дотор чинь янз янзын оруулж ирэхэд, тэр тусмаа дандаа нөгөө нэг импортлож байгаа байгууллагын зардлаар явдаг гэж байгаа шүү дээ. Зардлаар нь цаашаага

хил гардаг. Тэгээд тэнд ордог байр сууц тэр буудлын үнэ ханиш, юу үнэ зардал бүх юмыг нь нөгөө байгууллага нь импортолж байгаа байгууллага нь төлдөг. Тэдний зардлаар явдаг. Ямар шаардлагатай ингээж үзсэн юм, яг энэ эрсдэлийн энэ тохиолдолд.

Тэгээд ерөөсөө шууд эндээсээ томилоод хүн яваад л, томилоод л мэргэжлийн байгууллагатай харьцаад л эрсдэлийнхээ үнэлгээг хийгээд ир. Түүнээс биш хилийн цаана. Тэр 2 байгууллага хоорондоо, 2 байгууллага хоорондоо тийм зохицсон нөгөө хэлэлцээр байдаг юм гэнэ лээ. Нэг нэгэн рүүгээ очиж үзэж газар дээр нь юм үзнэ гэсэн тийм хэлэлцээр протоколтой байдаг юм гэсэн. Тэгээд тэрэндээ л явж байгаа юм байна лээ. Бүр байгуулахгүй болгочихсон ч болохгүй гэхгүй, миний хувьд болбол байхгүй болгосон ч болохгүй гэх юм алга байна л даа. Тийм нэгэнт тийм тохиролцоо хэлэлцээр байдаг юм бол тийшээгээ нэг их багсаад байх юм байхгүй. Тэгээд хамаг хүний зардлаар явдаг, очоод л лобби ордог. Тэгээд олонхоороо гар өргөөд нөгөө талдаа шийдээд юу гэдэг юм ямар нэгэн хууль бус шийдвэр гараад явчих юм болов уу гэдгээр урьдчилан сэргийлээд эндээс мал, амьтныхаа эрүүл мэндийг хариуцсан байгууллага шууд өөрсдөө томилоод хариуцлагаа үүр л гэж байгаа юм.

Б.Саранчимэг: Баярлалаа. Бейсен гишүүн асуултаа асууя.

Б.Бейсен: Энэ амьтан, ургамал, тэд нарын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй танилцлаа л даа. Өчигдөр ч би ажлын хэсэг дээр би бас эсрэг санал өгсөн. Энэ дээр энэ хууль дээр амьтан болон ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хууль байхад энэ удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр зөвхөн мал, амьтны гаралтай бүтээгдэхүүнийг

экспортлох, гэрчилгээ олгох эсэхэд анхааран өөрчилсөн байна гэж харж байгаа. Харин ургамлын хэсгийг боловсруулж өргөн барих гэж байгаа юм байна. Агентлаг байгуулахаар яаж байгаа юм байна. Шинээр агентлаг байгуулахаар төлөвлөж байгаа бол энэ зохицуулалт шинээр бий болох агентлагийг нь Төсвийн тухай хууль болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийг нийцэхгүй байвал яах вэ, батлагдахгүй байвал яах вэ нэг, 1 дүгээрт. Дээрх хууль батлагдахгүй бол амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүний тухай биш зөвхөн мал, амьтны хэсгийг өөрчлөөд, ургамлын хэсгийг өөрчлөхгүй орхигдуулж байгаа нь үгүй ээ яаж хүндрэл үүсэх вэ?

Энэ 5.4.1 дээр амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг Монгол Улсад импортлох өмнө эрсдэлийн үнэлгээ хийж импортын мэдэгдэл олгох гээд байж байгаа. Одоо бол гаалийн хорио цээрийн байгууллагаас импортын мэдэгдэл олгохдоо Улаанбаатар хот болон орон нутаг Хилийн боомтын гаалийн газар хоорондын хорио цээрийн хяналтын албадаар дамжуулан цахим системээр олгож байгаа. Ингээд сард нэг 200-гаад, жилд нэг 2300-аас 2500-гаад ширхэг юу олгож байгаа юм байна л даа. Гэтэл энэ Хөдөө аж ахуйн яаманд оччихоор чинь алслагдсан Увс, Ховд, Баян-Өлгий аймаг яах вэ энэ чинь? Яамнаасаа авахаар бас энэ аж ахуйн нэгжид хүндрэл учрах юм биш үү. Зөвхөн гэрчилгээ олгоод авлига аваад суудаг газар болох уу, энийг яах вэ, яаж шийдэх вэ? Энэ талаар асууя. Дараа нь бас тодруулъя.

Б.Саранчимэг: Ажлын алба, ажлын хэсэг хариулъя, 3 номер хариулъя.

Ц.Болорчулуун: Бейсен гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль өргөн барихад бэлэн болчихсон байж байгаа. Тэгээд энэ дээр бол энэ тухайн энэ асуудал хариуцсан агентлагтай байна гэдэг зохицуулалт бол

орсон. Энийг болбол Сангийн яамнаас бид нар зөвшөөрлөө аваад, Сангийн яам дэмжээд явчихсан байж байгаа. Тэгэхээр үүгээрээ болбол өргөн бариад хэлэлцээд явсан хэлэлцүүлээд батлагдсан тохиолдолд энэ ингээд цаашаа явчих бололцоотой гэж ингэж харж байгаа. Орон нутагт байгаа байцаагчид маань энэ цахимаар мэдээллээ илгээж, цахимаар энэ зөвшөөрлүүд олгогдох ёстой. Тэрнээс бол баруун аймагт байгаа ААН-үүд бол энэ тэр болгонд яам руу хандах ийм биеэр хандах ийм шаардлагагүй. Тэгэхээр энэ болбол цахимаар явна гэсэн мэдээллээ аваад, зөвшөөрлөө өгөөд байх ийм бололцоотой гэж ингэж харж байгаа.

Б.Саранчимэг: Бейсен гишүүн тодруулъя гэж байна.

Б.Бейсен: Энэ хуулийн 6.1 дэх хэсэгт хорио цээрийн хяналт шалгалтыг Монгол Улсын нутаг дэвсгэрт хорио цээрийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ гээд заачихсан байгаа шүү дээ. Одоо гаалийн байгууллага хэрэгжүүлж байгаа энийг тийм ээ. Хүнс, хөдөө аж ахуйн яам энэ эрхийг авахад хил дээрх хорио цээрийн хяналтын чиг үүрэг шилжүүлж авч болохгүй юм уу? Дараа нь энд бас гацаа үүсэх юм биш үү? Энэ талаар ямар бодолтой байна вэ ер нь?

Б.Саранчимэг: Бат-Эрдэнэ гишүүн хариулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Ер нь энэ хуулийн гол логик болбол ерөөсөө ургамал, амьтны хорио цээрийнхээ асуудлуудыг энэ ургамал, амьтнаа хариуцсан төрийн захиргааны байгууллага төрийн захиргааны төв байгууллагууд мэргэжлийн байгууллага хариуцаад явъя гэдэг ийм гол логик байгаа шүү дээ. Тэгээд энэ талаар олон улсын жишиг, одоо болбол жишээ нь манай дээр мал, амьтны эрүүл мэнд хариуцсан байгууллага нь болбол агентлаг болбол байж байгаа Мал, амьтны эрүүл мэндийн ерөнхий газар гэж байгаа байх тийм ээ, байгаа. Нөгөө

талаас яг хүнсний үйлдвэрлэл чиглэл дээрээ ингээд харахаар бол нэг талдаа болбол мал, амьтан нөгөө талдаа болбол ургамал болчхоод байна шүү дээ ургамал газар тариалан. Тэгэхээр ОУБ-аас болбол жишигээр ерөнхийдөө энэ ургамал хорио цээрийн тухай хуулиа гаргаад энийгээ хариуцсан агентлаг бай гэсэн ийм шаардлагыг тавиад байгаа юм. Тэгээд бид ч гэсэн ингээд харахад болбол үндсэндээ яг энэ ургамал, ургамал болон хорио цээртэй, ургамлын хорио цээртэй холбоотой бүүр мэргэшсэн байгууллага гүйцэтгэх байгууллага энд байх шаардлагатай болчхоод байгаа юм л даа. Тэгээд Ургамал хамгаалал, хорио цээрийн тухай хууль нь орж ирж байгаа. Тэр нь болбол дэмжигдээд явж байгаа юм байна. Түүн дотор болбол мэргэжлийн байгууллага бий болох нь болбол тодорхойлогдоод явж байгаа юм байна. Тэр хүртэл энэ яам өөрсдийнхөө хүрээнд болбол тэр яаман доторх бүтцээрээ болбол энийгээ хийгээд явж явж болно гэсэн ийм л тайлбарыг яамныхан өгч байгаа. Тийм сая ч бас тэрнийхээ зах зухаас нь болбол тайлбарлаад л байх шиг байна.

Б.Саранчимэг: Баярлалаа. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд дууслаа. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгийн саналаас 2 санал ирүүлсэн байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 5.4 дэх хэсгийн 5.4.2 дахь заалтын “гадаад орны” гэсний өмнө “хуульд өөрөөр заагаагүй бол” гэж, 5.4.3 дахь заалтын “экспортлох” гэсний өмнө “шаардлагатай бол” гэж нэмэх. Санал хураалт. Санал дэмжигдсэнгүй. Төслийн 1 дүгээр зүйл эхнийх байгаа төслийн 1 дүгээр зүйл тийм. Гишүүд ойлгомжгүй байна гэж байна шүү. Энэ дээр нэмэлт тайлбар хийх үү? Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгье.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ зарим гишүүд маань бас ойлгомжгүй байна гэж байна.

Энэ ажлын хэсэг энэ дээр яг Үндсэн хууль дээр ямар заалт байгаа билээ тэрийгээ бүүр дахиад нэг тайлбарлаад өгөөч. Тэгээд дахин санал хураалт явуулж өгөөч гэсэн саналтай байна.

Б.Саранчимэг: 4 номер тэгээд микрофоныг өгье.

Э.Цолмонжаргал: ХХААХҮЯ-ны Хуулийн хэлтсийн дарга Цолмонжаргал. Энэ заалт маань гадаад орны 5.4.2 дахь заалтын өмнө гадаад орны гэсний өмнө хуульд өөрөөр заагаагүй бол гэж нэмж байгаа. Энэ нь гадаад орны мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналтын байгууллагатай амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл мэнд, хорио цээрийн нөхцөлийг тохиролцох хяналт шалгалтын ажлыг уялдуулан хамтран ажиллах гэсэн ийм заалт байгаад байгаа. Тэгэхдээ энэ дээр яагаад гадаад юуны хуульд өөрөөр заагаагүй бол гэж оруулж байгаа вэ гэхээр энд нөгөө ургамлын асуудал маань давхар явж байгаа учраас энэ яамны эрх үүрэг дээр байгаа юм. Юуны мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан байгууллагын хувьд болбол малынх нь асуудал байгаа юм, бас нөгөө хорио цээрийн нөхцөл тохиролцох гэдэг нь. Тэгэхээр хуульд өөрөөр заагаагүй бол гэдэг нь Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулиар Мал эмнэлгийн ерөнхий газарт малынх нь асуудлаар чиг үүрэг нь байгаад байгаа учраас энийг хуульд өөрөөр заагаагүй бол гэж тухайлан зааж ургамлын асуудлыг нь тодруулсан байгаад байгаа.

Дараагийнх нь 5.4.3 дахь заалт гэдэг нь болбол нөгөө экспортлох үйлдвэр ААН-ийн нэгжид нэгжийн үйл ажиллагаанд нь хянан магадалгаа хийх асуудал байгаа. Энэ бүх тохиолдолд хянан магадалгаа хийхэд хийх, хийх нь хүндрэл учруулах учраас шаардлагатай бол гээд импортлогч орон өөрөө хүссэн тохиолдолд экспортлох эрхтэй үйлдвэр ААН-ийнхээ үйл ажиллагаанд хянан магадалгаагаа хийе гэдэг агуулгаар шаардлагатай бол гэдэг ийм заалт, үг

үсэг нэмж байгаа юм. Хуучнаараа үлдэх юм бол бүх тохиолдолд хянан магадалгаа хийх болно. Экспортлох бүх бүтээгдэхүүн дээр хянан магадалгаа хийх асуудал үүснэ. Нөгөөдөх нь болохоор нөгөө Мал, амьтны эрүүл мэндийн хуультайгаа давхардсан заалт болчих юм.

Б.Саранчимэг: Бат-Эрдэнэ гишүүний, тайлбарыг сонслоо. Бат-Эрдэнэ гишүүний саналаар түрүүний санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Санал хураалтыг цуцалъя. Би явлаа шүү, энэ санал дэмжигдсэнгүй. Дараагийнхаа санал руу оръё. Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалт буюу 3.1.11 дэх заалтын “мал, амьтан,” гэсний дараа “ургамал,” гэж нэмэх. Санал хураалт. 70 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс 1 саналын томъёолол гаргасан байна. Төслийн 2 дугаар зүйлийн “26.1 дэх хэсэг,” гэснийг “26.1 дэх хэсгийн “эрүүл мэндийг хамгаалах” гэсний өмнө болон” гэж өөрчилж, “8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалтын “байгууллагад” гэсний дараа “цахимаар” гэж,” гэснийг хасах. Санал хураалт, анхаараарай гишүүдээ. Санал хураалт битгий яг санал хураалтын үеэр яагаад байгаа юм бэ. 70 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Дараа нь тэрийгээ эхлээд яагаад. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс саналын томъёолол 2 ирсэн байна. Төслийн 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 27.1 дэх хэсгийн “мэргэжлийн баг” гэснийг “эрх бүхий албан тушаалтан” гэж, 27.2 дахь хэсгийн “мэргэжлийн багийн” гэснийг “эрх бүхий албан тушаалтны” гэж өөрчилж, төслийн 2 дахь заалт буюу 26.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 26.4, 26.5 дахь хэсэг болгох:

“26.4.Эрсдэлийн үнэлгээг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилогдсон эрх бүхий албан тушаалтан гүйцэтгэнэ.

26.5.Энэ хуулийн 26.4-т заасан эрсдэлийн үнэлгээ хийх журмыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” Санал хураалт. 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7.1.7 дахь заалт нэмж, төслийн 6 дугаар зүйлийн “7.1.7,” гэснийг хасах:

“7.1.7.гадаад орны мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн байгууллагатай хяналт, шалгалтын ажлыг уялдуулан хамтран ажиллах, улсын хилээр нэвтрүүлсэн амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүний талаарх мэдээллийг тогтоосон хугацаанд хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахимаар хүргүүлэх;” Санал хураалт. Дараагийнхад нь. Санал хураалт. 60 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу, асуулт асуух гишүүд байна уу? Асуулт асуух гишүүд алга. Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс саналын томъёолол 2 санал ирсэн байна. Анхаараарай гишүүдээ. Төслийн 4 дүгээр зүйлийн “тус тус, 8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалтын” гэсний өмнө “, 25 энэ гэсний өмнө, 25 дугаар зүйлийн гарчгийг “Импортын, олон улсын мал эмнэлгийн, ургамлын хорио цээрийн гэрчилгээ” гэж” гэж нэмэх. Санал хураалт. Та нар ирээд хэлээд байхаач. Анхаарч байхгүй. Санал хураалт. Бат-Эрдэнэ чи бүр ингээд юу яагаад байх юм. Ганболд гишүүн санал хэлье.

Г.Ганболд: Би сая энэ 6 дугаар санал хураалтыг уг нь энэ заалтыг

дэмжсэн юм. Тэгээд төхөөрөмж ажилласангүй эсрэг гарчихлаа. Тэгээд санал хураалтыг хүчингүй болгож өгч дахин санал хураалт явуулж өгөөч.

Б.Саранчимэг: Хүлээж байгаа юм. Ганболд гишүүний саналаар энэ санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Санал хураалт хүчингүй боллоо. Санал хураалт. Үгүй хүлээж бай, санал одоо энэ санал хураалтыг уншсан байгаа. Дахиж унших уу? Санал хураалт. Тэгээд анхаараад яваад дахиж энэ, тус тусад нь анхаараад явчихмаар байна. Үгүй ээ тэгэхээр яг юун дээр нь саналаа хэлнэ шүү дээ. Санал 70 хувиар дэмжигдлээ. Төслийн 4 дүгээр зүйлийн, санал, хүлээж бай, уучлаарай. Санал хураалт явчихсан. Одоо дахиад би юмаа уншсаны дараагаар ярих байхгүй юу.

Төслийн 4 дүгээр зүйлийн ““мэдээг тогтоосон хугацаанд” гэснийг “тухай бүр”” гэснийг ““хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий” гэснийг “дээд шатны”” гэж өөрчилж, “, 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалтын” гэснийг болон “27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэг,” гэснийг тус тус хасах. Санал хураалт. Одоохон, 60 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Бат-Эрдэнэ гишүүн, микрофон өөрөө кнопоо дараач. Асуулт асуух гишүүд байна уу, нэрсээ өгье. Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал гараагүй байна.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Зарчмын зөрөөтэй санал гараагүй байна.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Хуулийн төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс саналын томъёолол 1 санал бэлтгэсэн

байна. Төслийн 7 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7 дугаар зүйл. Энэ хуулийг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал хураалт. Санал хураалт, санал хураалт. 70 хувиар санал дэмжигдлээ. Найруулгын 3 санал байна. Найруулгын 3 саналаас өмнө бичгээр ирүүлсэн бас нэг санал байна. Мөн үү? Ажлын хэсгийн дарга Бат-Эрдэнэ гишүүн өөрөө саналаа гаргаад явчих уу? Тайлбарлаад явчхаарай.

Ж.Бат-Эрдэнэ: Амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 25 дугаар хэсэг гээд сая бид нар хэлэлцээд өнгөрсөн энэ 25 дугаар хэсэг дээр ажлын хэсгээс оруулсан нэг санал байсан нь ажлын хэсэг дээр бол унасан юм. Тэгээд энийг би бас эргэж оруулж хэлэлцүүлж гэсэн ийм саналыг оруулж байгаа юм. Энд Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.2 дахь хэсэг нэмэх, төслийн 4 дүгээр зүйлийн “25.2,” гэснийг хаах, хасах:

“25.2.Хорио цээрийн хяналт, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний дүн, энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг харгалзан ургамлын хорио цээрийн гэрчилгээг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, олон улсын мал эмнэлгийн гэрчилгээг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тус тус олгоно.” Тэгээд энэ дээр ямар гэсэн нэмэх ийм саналыг оруулж ирж байгаа юм. Энэ дээр ямар асуудал гарсан юм гэхээр түрүүн хэлсэн, бид нарын асуугаад байсан асуулт шүү дээ. Мал, амьтных нь асуудал болбол ингээд агентлагийнхаа хүрээнд шийдэгдээд явчих юм байна. Ургамлынх нь асуудлуудыг яаж шийдэх юм бэ. Энэ

дээр болбол боловсон хүчний асуудал нь хүрэлцэх юм уу хүрэлцэхгүй юм уу гэдэг дээр жоохон маргаан гараад, тэгээд энэ уначихсан юм. Тийм болохоор сая болбол яамныхан болбол тайлбарлалаа шүү дээ, өөрсдийнхөө хүрээнд болбол хийгээд явах бүрэн бололцоотой гэсэн ийм тайлбар өгсөн байгаа юм. Тийм болохоор энэ саналыг болбол санал хураалт хийж өгнө үү гэсэн ийм саналыг оруулж ирж байгаа юм.

Б.Саранчимэг: Би бүтнээр нь унших ёстой. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.2 дахь хэсэг нэмж, нэмэх, төслийн 4 дүгээр зүйлийн “25.2,” гэснийг хасах: бас уншаад хянаад яваарай Бат-Эрдэнэ гишүүнээ.

“25.2.Хорио цээрийн хяналт, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний дүн, энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг харгалзан ургамлын хорио цээрийн гэрчилгээг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, олон улсын мал эмнэлгийн гэрчилгээг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тус тус олгоно.” гэж нэмэх. Санал хураалт. Энийг дараагаар аль билээ? 60 хувиар санал дэмжигдлээ.

Дараа нь найруулгын 3 санал байна. Та бүхэнд уншиж танилцуулъя. 1.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 1.1 дэх хэсгийн “хангах, худалдааг хөнгөвчлөх” гэснийг “дэмжих” гэж өөрчлөх.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 5.4 дэх хэсэг, 3 дугаар зүйлийн 3 дахь заалт буюу 27.2 дахь хэсэг болон 4 дүгээр зүйлийн “хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн” гэсний өмнө “хүнс,” гэж нэмэх.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтыг 1 дэх заалт болгон өөрчлөх. Санал хураалт. Найруулгын 3 санал байна. 70 хувиар санал дэмжигдлээ. Энэ асуудлыг хэлэлцэж дууслаа.

Хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслийг зүйл бүрээр энэ хэлэлцэнэ. Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Байна уу? Наранбаатар гишүүн асуулт асууя.

Н.Наранбаатар: Энийг болохоор би ингэж ойлгоод байгаа шүү дээ. Тусгай чиг үүргийн байгууллагын жагсаалтад оруулж байгаа гэж ойлгож байгаа зөв үү? Мал эмнэлгийн албыг. Энэ өнөө дээр нь нэмээд нэг юм асуухад сумд ажиллаж байгаа тасгийн малын эмч нарыг өнөө 5 жилийн урамшуулал байгаа шүү дээ тийм ээ, аймгийнх байгаа юу, үгүй юу? Аймгийн төв дээр ажиллаж байгаа энэ газарт ажиллаж байгаа малын эмч нарын 5 жилийн тутам нөгөө 6 сарын цалингийн нэмэгдэл гэдэг юм ер нь байгаа юу? Байхгүй бол оруулах боломж байна уу үгүй юу? Зарчмын зөрүүтэй санал энэ тэр гаргаад. Түүн дээр нэг мэдээлэл өгөөдхөөч.

Б.Саранчимэг: 3 номер хариулах уу? 3 номерын микрофоныг өгье.

Ц.Болорчулуун: Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Тэр таны хэлж байгаачлан энэ тусгай чиг үүргийн байгууллагын жагсаалт нь Мал эмнэлгийн ерөнхий газрыг бол ингэж оруулахаар хуульчилж өгч байгаа. Энэ бол мэдээж олон талын ач холбогдолтой гэдгийг бол та бүгд мэдээж байгаа.

Тэгээд 2 дахь асуулт болох тэр сумын малын эмнэлэг дээр болбол цалин хөлсний асуудал байгаа, аймгийн түвшинд

бол байхгүй. Тэгээд одоо энийг бол энд хөндөгдөөгүй учраас ийшээ оруулах боломж байхгүй л гэж харж байгаа.

Б.Саранчимэг: 1 дүгээр зүйлтэй холбогдуулж гишүүд асуулт асууж дууслаа. Зарчмын зөрүүтэй санал энэ дээр гараагүй байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс саналын томъёолол 1 ирсэн байна. Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал хураалт. Хүлээж бай, эхлээд дуусгаадахъя, бүгдийг нь дуусгая. 70 хувиар санал дэмжигдлээ. Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Малын генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс 3 саналын томъёолол гарсан байна. Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу “9.13, 9.14 дэх хэсэг” гэснийг “9.14, 9.15 дахь хэсэг” гэж, төслийн 3 дахь заалт буюу 9.2.3 дахь заалтын “3-аас” гэснийг “гурваас” гэж өөрчлөх. 3 гэсэн тоогоор бичсэнийг задлаад үсгээр гурваас гэж өөрчлөх. Санал хураалт. 60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу “16 дугаар зүйлийн 16.12” гэсний дараа “, 16.13” гэж нэмж, 16.13.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.13.4.малын тэжээл, шимт чанар, хүрэлцээ, бэлчээрийн менежмент болон усан хангамж, аймаг дундын отрын бэлчээрийн ашиглалт, хамгаалалт, холбогдох журмын хэрэгжилт, малын гаралтай түүхий эд бэлтгэл;” Санал хураалт. 70 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтыг 1 дэх заалт, 3 дугаар зүйлийн 3 дахь заалтыг 1 дэх заалт болгон өөрчлөх. Санал хураалт. 70 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Зарчмын зөрүүтэй санал гараагүй байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. Зарчмын зөрүүтэй санал гараагүй байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. Зарчмын зөрүүтэй санал гараагүй байна.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс саналын 1 томъёолол ирсэн байна. Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5 дугаар зүйл.Энэ хуулийг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал хураалт. 60 хувиар санал дэмжигдлээ. Малын генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух

гишүүн байна уу? Алга байна. Зарчмын зөрүүтэй санал гараагүй.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс саналын томъёолол 1 ирсэн байна. Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал хураалт. Ганболд гишүүн санал хэлье.

Г.Ганболд: Саяын саналыг дэмжсэн, төхөөрөмж ажиллахгүй байна. Тэгээд гацаад эсрэг гарчихлаа, саяын санал хураалтыг хүчингүй болгож өгнө ҮҮ.

Б.Саранчимэг: Ганболд гишүүний саналын дагуу энэ саналыг хүчингүй болгох санал хураалт явуулъя. Тийм түрүүлж энэ чинь байж магадгүй. 70 хувиар санал дэмжигдлээ, санал хүчингүй боллоо. Одоо санал хураалтыг дахин явуулъя. Санал хураалт. 70 хувиар санал дэмжигдлээ. Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс саналын томъёолол 1 ирсэн байна. Төслийн 1 дүгээр зүйлийн “6.63 дахь хэсэг” гэснийг “6.64 дэх хэсэг” гэж, “6.63.” гэснийг “6.64.” гэж өөрчлөх. Санал хураалт. Энэ одоо дахиад, санал хураалт, харин. 70 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс саналын томъёолол бэлтгэсэн байна. Төслийн 2 дугаар зүйлийн “, 8, 9, 10, 11” гэсний дараа “, 12” гэж нэмэх. Санал хураалт. 70 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Зарчмын зөрүүтэй санал гараагүй байна.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. Зарчмын зөрүүтэй санал ирээгүй байна.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс саналын 1 томъёолол ирсэн байгаа. Төслийн 5 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах: гэсэн санал хураалт, өөрчлөн найруулах.

“5 дугаар зүйл. Энэ хуулийг Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал хураалт. 70 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр бүхий, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал хураалт. Болорчулуун сайдаа санал хураалт. Одоо энийг ярина тийм ээ. Санал 70 хувиар санал дэмжигдлээ. Наранбаатар гишүүн санал хэлье гэж байна. Микрофоныг өгье.

Н.Наранбаатар: Тэр Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх буюу хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт,

өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх санал хураалт дээр 1 дүгээр зүйл дээр биз дээ, 1 дүгээр зүйл дээр тийм, 1 дүгээр зүйл дээр санал хураалт дээр төхөөрөмж ажиллаагүй учраас хүчингүй болгож өгнө үү. Санал хураалтыг хүчингүй болгож өгнө үү.

Б.Саранчимэг: Наранбаатар гишүүний саналаар энэ саналыг хүчингүй болгох, санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя. Санал хураалт. 60 хувиар санал дэмжигдлээ. Энэ санал, одоо би дахин санал, санал хураалтын томъёоллыг та бүхэнд уншиж танилцуулъя. Яамдын ажлын хэсгийн тайлбарлаж байгаагаар улам хүнд суртлыг бол багасгаж байгаа гэж ойлгосон. Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 5.4 дэх хэсгийн 5.4.2 дахь заалтын “гадаад орны” гэсний өмнө “хуульд өөрөөр заагаагүй бол” гэж, 5.4.3 дахь заалтын “экспортлох” гэсний өмнө “шаардлагатай бол” гэж нэмэх. Санал хураалт. Тийм, 60 хувиар санал дэмжигдлээ. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Бат-Эрдэнэ танилцуулна.

12.16 цаг

Өнөөдрийн Байнгын хорооны хуралд идэвхтэй оролцсон Улсын Их

*Хурлын эрхэм гишүүд болон ажлын
хэсгийнхэнд баярлалаа. Хурал дууслаа.*

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ*

БУУЛГАЖ, ХЯНАСАН:

ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

